



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ, СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

**“МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО, АМИА
ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДОЛ, АРХИ МАНСУУРУУЛАХ
БОДИСЫН ХЭРЭГЛЭГЧ БОЛОН ДОНТОГЧИЙГ БҮРТГЭХ
МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЖ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН
НЭГДСЭН СҮЛЖЭЭГ ҮҮСГЭХ” ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭМЖИХ САНГИЙН
САНХҮҮЖИЛТТЭЙ СУДАЛГААНЫ ТӨСӨЛТ АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024он



ТАЛАРХАЛ

Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүрт мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх судалгааг хийхэд дэмжлэг үзүүлсэн Эрүүл мэндийн сайд С. Чинзориг, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нарт талархсанаа илэрхийлье. Мөн судалгааг зохион байгуулах, мэдээлэл цуглуулахад өөрсдийн туршлага, санал бодлоо бидэнтэй хуваалцаж дэмжлэг үзүүлсэн Эрүүл мэндийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Нэгдсэн үндэсний байгууллага, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын - Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл), Нийслэлийн түргэн тусламж 103, Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Аддиктологийн төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүүхдийн тусламж 108 утас, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийг дэмжих сан болон бусад манай төсөлтэй хамтарч, дэмжиж ажилласан нийт байгууллагуудын удирдлага болон хамт олон, мэргэжилтнүүдээ талархал илэрхийлье.

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛОН

- Эрүүл мэндийн яам
- Хууль зүй дотоод хэргийн яам
- Боловсрол шинжлэх ухааны яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
- Нэгдсэн үндэсний байгууллага, Хүүхдийн сан
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
- Монгол Улсын ерөнхий прокурорын газар,
- Монгол улсын үндэсний статистикийн хороо
- Эрүүл мэндийн хөгжлийн төв
- Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс
- Цагдаагийн ерөнхий газрын - Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах хэлтэс
- Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
- Гэмтэл согог судлалын үндэсний төв



- Шүүх шинжилгээний ерөнхий газар
- Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв
- Нийслэлийн эрүүл мэндийн газар
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)
- Нийслэлийн түргэн тусламж 103
- Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
- Аддиктологийн төв
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
- Хүүхдийн тусламж 108 утас

СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАГЧ:

- В. Баярмаа, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗӨВЛӨХ:

- Э. Оюунсүрэн, Анагаах ухааны доктор (Ph.D), дэд профессор, ЭМЯ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИЦУУЛАГЧ:

- Т.Ганцэцэг, Анагаах ухааны доктор (Ph.D), дэд профессор, СЭМҮТ

СУДАЛГААНД ОРОЛЦСОН СУДЛААЧИД:

- Д.Баясгалан – ЭМЯ - Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн шинжээч
- Баяртулга - ЭМЯ - Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Б.Цэрэн-Очир - ЭМЯ - Ахлах мэргэжилтэн
- Н.Гантулга – ЭМХТ - Мэдээллийн ахлах мэргэжилтэн
- Д.Болорчимэг - НҮБ-ын Хүүхдийн сан- Хүүхэд, өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- С.Болорцэцэг - НҮБ-ын Хүүхдийн сан- Хүүхэд, өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- О.Болормаа - ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтэн
- Д.Анужин – ХЗДХЯ - Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн
- Д.Анхзаяа – БШУЯ - Цахим бодлого, статистикийн хэлтсийн шинжээч
- Б.Дуламсүрэн – БШУЯ - Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын шинжээч
- Д.Мөнхзул - ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа
- Б.Эрхэсбаатар - ЦЕГ-ын ХТТГ, Эрүүгийн цагдаагийн III тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
- О.Уулзахаргал – ЦЕГ-ын ХТТГ, Эрүүгийн ахлах мөрдөгч
- Г.Золжаргал – ЦЕГ - Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн хошууч
- Д.Нямдаваа – ЦЕГ, Мөрдөн байцаах алба



- Ц.Мөнхбат – ШШЕГ, Бүртгэл мэдээлэл технологийн албаны дарга
- Э.Шинэцэцэг – ШШЕГ, Статистикийн мэргэжилтэн
- М.Биндэръяа – ҮСХ, Мэдээллийн технологийн газрын Программ хангамжийн хэлтсийн дарга
- Э.Ариунчимэг- ҮСХ, Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн эрүүл мэндийн салбар хариуцсан статистикч
- Р.Гантуяа – ГССҮТ, ЭМТҮ хариуцсан дэд захирал
- А.Жаргалмаа – ГССҮТ, СТСА-Эпидемиологич
- Б.Баянзул – ГССҮТ, СТСА-НЭМ мэргэжилтэн
- Б.Оюунмаа – ГССҮТ, МТА-Мэдээллийн технологич
- н. Дэлгэрмаа – ЭХЭМҮТ, Сэтгэл зүйч
- С.Даваажаргал – ЭМХТ, ЭММА-ны Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн
- Б.Сарантуяа – ЭМХТ, ЭММА-ны Мэдээллийн технологийн өгөгдөл солилцоо хариуцсан мэргэжилтэн
- О.Анужин – НЭМҮТ, Мэдээллийн технологийн ажилтан
- Б.Баярмаа - НЭМҮТ (хор судлал), Шуурхай албаны дарга
- А.Алтанзагас - НТТ /103/, Албаны орлогч дарга
- н.Цэнгэлмаа - Хордлогын төв, Хордлогын төв дарга Эмч
- н.Отгонгэрэл - Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ, дарга
- н.Санчир – ХЭҮТ, Үйлчилгээний менежер
- А.Нямсүрэн - Аддиктологийн төв эмнэлэг, Даатгалын эмч, статистик дүн бүртгэгч.
- В.Баярмаа – СЭМҮТ, ерөнхий захирал
- З.Хишигсүрэн – АШУҮИС, СЭМТ-ийн эрхлэгч, Анагаах ухааны доктор (Ph.D), профессор,
- Т.Ганцэцэг - СЭМҮТ, СТСА-ны дарга
- Э.Маралмаа - СЭМҮТ, НЭМЭШСГХ-СТСМТА-ны мэргэжилтэн
- Х.Цогтбаяр – СЭМҮТ, Мэдээллийн технологийн ахлах мэргэжилтэн
- О.Батчимэг - СЭМҮТ, НЭМЭШСГХ-СТСМТА-ны мэргэжилтэн

СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:

- Т.Ганцэцэг, Анагаах ухааны доктор (Ph.D), дэд профессор, СЭМҮТ

АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН:

- Н.Алтанзул, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ
- Э. Маралмаа, АУ-ны магистр, СЭМҮТ

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

- В.Баярмаа, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ
- Э. Оюунсүрэн, АУ-ны доктор , дэд профессор, ЭМЯ



ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
ХУРААНГУЙ	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	
1.1 Судалгааны ажлын үндэслэл	10
1.2 Судалгааны ажлын зорилго, зорилтууд	11
1.3 Судалгааны ажлын шинэлэг тал	12
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ	
2.1 Судалгааны загвар, хамрах хүрээ	13
2.2 Судалгаанд оролцогчдыг хамруулах болон хасах шалгуур	15
2.3 Судалгааны хэрэглэгдэхүүн ба мэдээлэл цуглуулсан арга	16
2.4 Судалгааны ажлын ёс зүй	17
2.5 Судалгааны үр дүнгийн боловсруулалт	17
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	
3.1 Нэг дүгээр зорилтын хүрээнд хийсэн ажлын үр дүн	18
3.2 Судалгааны хоёр дугаар зорилтын хүрээнд хийсэн ажлын үр дүн	27
3.3 Судалгааны гурав дугаар зорилтын үр дүн	31
ДҮГНЭЛТ	32
НОМ ЗҮЙ	33
ХАВСРАЛТ	
Хавсралт 1;2 Бүртгэх маягт	34
Хавсралт 3 Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журамын төсөл	44
Хавсралт 4 Сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл мэдээллийн тогтолцоонд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт, тайлбар	63
Хавсралт 5 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд СЭМҮТ-өөс амиа хорлолтой холбоотой өгсөн санал	65



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ASSISST	Архи мансуурлах бодисын хэрэглээг илрүүлэх асуулт
АУ	Анагаах ухаан
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны их сургууль
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МТА	Мэдээллийн технологийн алба
НТТ	Нийслэлийн түргэн тусламж
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМЭШСГХ-ТСМТА	Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт гадаад харилцаа, танталт судалгаа, мэдээлэл технологийн алба
СТСА	Статистик тандалт судалгааны албаны дарга
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХТМБИХН	Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг
ХТТГ	Хар тамхитай тэмцэх хэлтэс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШЕГ	Шүүх шинжилгээний ерөнхий газар
ЭММА	Эрүүл мэндийн мэдээллийн алба
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ	Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Хамтран ажилласан байгууллагуудын нэрс	13
Хүснэгт 2	Хамрагдагсдыг судалгаанаас хасах болон оруулах шалгуурууд	17
Хүснэгт 3	Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд ашиглаж буй бүртгэлийн маягт ба цахим программын мэдээлэл	28
Хүснэгт 4	Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд ашиглаж буй бүртгэлийн маягт ба цахим программын мэдээлэл	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “Хүн ам зүйн мэдээлэл” –д өгсөн санал	18
Зураг 2	Архи мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Хүн ам зүйн мэдээлэл” –д өгсөн санал	19
Зураг 3	Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “Нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд” –д өгсөн санал	20
Зураг 4	Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “Эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүд” –д өгсөн санал	21
Зураг 5	Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “нөхцөл байдлын үнэлгээний үзүүлэлтүүд” –д өгсөн санал	22
Зураг 6	Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Өсөж бойжсон гэр бүлийн талаарх асуумж” –д өгсөн санал	23
Зураг 7	Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Эрүүл мэндийн байдлыг үнэлэх үзүүлэлт” –д өгсөн санал	24
Зураг 8	Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Гэмт хэрэгт холбогдож байсан талаарх асуумж” –д өгсөн санал	25
Зураг 9	Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Эмчилгээний төрөл ба хийгдсэн эмчилгээний түүхийг үнэлэх” –д өгсөн санал	26



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



“МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО, АМИА ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДОЛ, АРХИ МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХЭРЭГЛЭГЧ БОЛОН ДОНТОГЧИЙГ БҮРТГЭХ МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЖ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГДСЭН СҮЛЖЭЭГ ҮҮСГЭХ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ

Түлхүүр үг: амиа хорлох, архи, эм, бүртгэл, журам

Үндэслэл: Амиа хорлолт нь нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болсоор байгаа бөгөөд (ДЭМБ, 2021) өсвөр насныхны нас баралтын тэргүүлэх шалтгааны 4 дүгээрт амиа хорлолт орж, амиа хорлолтын нийт тохиолдлын 77% нь хөгжиж буй болон ядуу буурай орнуудад бүртгэгдэж байна. Монгол улсын хувьд 2021 оны байдлаар, 100000 хүн амд ноогдох амиа хорлож нас барсан дундаж тохиолдлын тоо 15.0 байгаа нь дэлхийн дунджаас (10.6), 4.4-өөр, бүсийн дунджаас (10.2) 4.8-аар илүү байгаа нь Номхон далайн Баруун эргийн бүсийн хэмжээнд 5 дугаарт орж буй үзүүлэлт болж байна. Манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 16.9 мянган хүн нас барснаас 2.8% орчим нь амиа хорлож нас баржээ. 2010-2019 оны дунджаар нийт нас барсан хүн амын 60.5%, амиа хорлож нас барсан тохиолдлын 85% нь эрэгтэй хүйсийнх байв. Монгол улсын Эрүүл мэндийн үзүүлэлт 2021- оос үзвэл 2021 онд 483 хүн амиа хорлож нас барсан ба энэхүү үзүүлэлтийг 10 000 хүн амд харьцуулахад 1.5 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 19, 2020 онтой харьцуулахад 32 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна.

ДЭМБ-ын тайланд нийт 103 улс оронд хийсэн судалгаанаас харахад 11.9% нь архинд донтох эмгэгтэй байна. Үүнээс харахад архи, мансууруулах хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн эзлэх хувь жилээс жилд ихсэж байгаа боловч эмчилгээ үйлчилгээнд хамрагдах байдал нь хангалтгүй байсаар байна гэжээ.

Манай улсад ДЭМБ-ын санхүүжилтээр хийсэн судалгаагаар дэгдэмхий уусгагч бодисын хэрэглээ 5.3% байсан ба сэтгэц идэвхт бодисын хэрэглээ 22% (33) байгаагаас каннабис (8.7%), харин тайвшруулах, нойрсуулах эм (8%) зонхилж байна. Мөн ЕБС-ийн 9-10-р ангийн 1000 сурагчдын дунд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 9% нь мансууруулах бодис хэрэглэж байсан. СЭМҮТ-ийн 2013 оны Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаагаар архинд донтох эмгэг 6.2% байсан бөгөөд 1986-1992 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад архинд донтох эмгэг 40 дахин ихэссэн байна.

Гэтэл Монгол улсын ерөнхийлөгчийн 2019 оны 05 сарын 30 өдрийн 104 дүгээр дугаартай зарлигийн 12 ба 13 дугаарт зүйлд Монгол улсын хэмжээнд амиа хорлож нас барсан болон амиа хорлох оролдлого тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болох гэсэн бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” тунхагласан зорилгын 3.5.1-д “Үндэсний хэмжээнд мансууруулах бодис ба архинд донтох эмгэгийн тархалт, эмчилгээний хамралтыг судлах”, 3.4.2-д “Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин” заасан шалгуурыг хангах ажлын хүрээнд 2018-2019 онд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс гаргасан (06/05 тоот зөвлөмж, 1а/2551 албан тоот) үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллах үүргийг биелүүлэхийн тулд энэхүү судалгааны ажлыг хийх хэрэгцээ шаардлага буюу үндэслэл болж байна.

Зорилго: Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэн, журам боловсруулж, эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах



Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй: Уг судалгааны ажлыг аналитик болон чанарын судалгааны нэг агшны загвараар, асуумж болон баримтын судалгааны аргыг ашиглаж 3 үе шаттай хийсэн. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах стандарт асуумж, маягтыг боловсруулах, батлуулах, нэгдсэн мэдээллийн цахим санг үүсгэхийн тулд 4 бүлэг, 231 асуултаас бүрдсэн судалгааны асуумжийг нийт 23 байгууллагатай хамтарч ажиллаж үр дүнг тооцож анхан шатанд хөтлөгдөх карт болон цахим санд орох өгөгдлүүдийг боловсруулж, 4 яамны хамтарч ажиллах журмын төслийг боловсруулж санал асуулга авсан. Улсын болон хувийн нэр бүхий 23 байгууллагуудтай хамтран ажиллаж бүлгийн ярилцлага болон баримтын судалгааны арга ашиглаж 2022 оны 08 дүгээр сараас эхэлж 2023 оны 07 сар хүртэл судалгаа хийсэн. Эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй дотоод хэргийн яамны 4 сайдын хамтарсан журмыг 2023 оны 11 сард боловсруулан танилцуулж 2023 оны 12 сард ЭМЯ-д хүлээлгэж өгсөн. 2024 оны 03 сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулсан.

Судалгааны мэдээллийг нэгтгэж, статистик боловсруулалтыг SPSS 24 программыг ашиглан хийж гүйцэтгэв. Судалгааны ёс зүйг ЭМЯ-ны ёс зүйн хорооны 3 сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж ёс зүйн зөвшөөрөл авсан (№267)

Үр дүн: Бид судалгаанд оролцогч байгууллагуудаас оролцогч нараас амиа хорлох ба архи мансууруулах бодисын шалтгаант хэрэглээ ба донтолын тохиолдлуудыг бүтгэхэд: “Амиа хорлох оролдлого хийсэн, хорлож нас барсан тохиолдол, архинд донтох эмгэг ба мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч”-ийг бүртгэх гэсэн 4 сэдвийн хүрээнд эрүүл мэндийн салбарт (4 нь маягт), эрүүл мэндийн бус салбарт (4 нь маягт), бүх шатны боловсролын салбарт (2 маягт) бүртгэх гэсэн 3 нь ангиллаар нийт 10 маягт боловсруулсан. Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, шинжлэх ухаан гэсэн үндсэн 4 салбарын хамтарсан “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай” нэртэй 19 хуудас бүхий журам ба нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг боловсруулсан. Цаашид 4 сайдын тушаал батлуулах эсвэл Засгийн газрын тогтоол гаргуулж нэгдсэн санг бий болгох, эх серверээр хангах, холбох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Дүгнэлт:

1. Бүртгэлийн хуудсыг эрүүл мэндийн салбарт, эрүүл мэндийн бус салбарт, бүх шатны боловсролын салбарт бүртгэх гэсэн 3 нь ангиллаар боловсруулах нь шаардлагатай.
2. “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай” журам ба нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг боловсруулж батлуулах нь тулгамдсан асуудал болж байна.
3. Уг журмыг эцэслэн боловсруулж 4 сайдын тушаалаар эсвэл Засгийн газрын тогтоолоор батлуулж орон даяар буюу хот, аймаг, дүүрэг, сум, багийн засаг дарга нарт үүрэг өгч хамтарч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь чухал байна.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

Үндэслэл: Амиа хорлолт нь нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болсоор байгаа бөгөөд (ДЭМБ, 2021) өсвөр насныхны нас баралтын тэргүүлэх шалтгааны 4 дүгээрт амиа хорлолт орж, амиа хорлолтын нийт тохиолдлын 77% нь хөгжиж буй болон ядуу буурай орнуудад бүртгэгдэж байна. Монгол улсын хувьд 2021 оны байдлаар, 100000 хүн амд ноогдох амиа хорлож нас барсан дундаж тохиолдлын тоо 15.0 байгаа нь дэлхийн дунджаас (10.6), 4.4-өөр, бүсийн дунджаас (10.2) 4.8-аар илүү байгаа нь Номхон далайн Баруун эргийн бүсийн хэмжээнд 5 дугаарт орж буй үзүүлэлт болж байна. Манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 16.9 мянган хүн нас барснаас 2.8% орчим нь амиа хорлож нас баржээ. 2010-2019 оны дунджаар нийт нас барсан хүн амын 60.5%, амиа хорлож нас барсан тохиолдлын 85% нь эрэгтэй хүйсийнх байв. Монгол улсын Эрүүл мэндийн үзүүлэлт 2021-оос үзвэл 2021 онд 483 хүн амиа хорлож нас барсан ба энэхүү үзүүлэлтийг 10 000 хүн амд харьцуулахад 1.5 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 19, 2020 онтой харьцуулахад 32 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Дэлхий дахинаа амиа тохиолдлуудын ихэнх хувийг боомилох, галт зэвсгээр өөрийгөө хөнөөх аргууд эзэлдэг ба хөдөө аж ахуй, газар тариалан хөгжиж буй бага болон дунд орлоготой улс орнуудад пестицидээр өөрийгөө хордуулах аргыг илүү хэрэглэж байна. Харин Монгол улсад өөрийгөө боомилох (n=434), галт зэвсгээр өөрийгөө хөнөөх (n=15), санаатайгаар өндрөөс үсрэх (n=8) аргууд нь нас баралтын тэргүүлэх 3 шалтгаан болж байна. Монгол улсад амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшнийг тодорхойлох судалгаа нь хязгаарлагдмал түвшинд 1997, 2008 онуудад хийгдсэн ба 2017 онд Монгол улсын Ерөнхий прокурорын газраас хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгааг тус тус хийжээ. Гэвч өнөөгийн байдлаар хүн амын дундах амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшнийг үндэсний хэмжээнд өргөн цар хүрээтэй хийсэн судалгаа байхгүй, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо байхгүй байгаа нь салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад саад болсоор байна. Нөгөө талаас НҮБ болон ДЭМБ-ын 2017 оны мэдээгээр дэлхий дээр 15-64 насны ойролцоогоор 271 сая хүн хууль бусаар мансууруулах бодис амьдралдаа нэг удаа хэрэглэсэн, мөн 2.3 тэрбум хүн архи, согтууруулах ундааг хэрэглэдэг гэсэн тооцоо байдаг. Өнөөдөр дэлхийд 35 сая хүн мансуурах бодис хэрэглэх эмгэг, 289 сая хүн архинд донтох эмгэгээр шаналж байна гэсэн тооцоо бий.

Донтох эмгэг гэдэг нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний улмаас эмнэлзүйн болон үйл ажиллагааны алдагдал илэрч, энэ нь хөдөлмөрийн чадвар алдалт, ажил сургууль завсардалтад хүргэдэг эмгэгийг хэлнэ. Мансууруулах бодис хэрэглэх эмгэгийг эмчлэхгүй бол нийгэм эдийн засагт олон сөрөг үр дагаврыг бий болгодог болохыг судлаачид тогтоогоод байна. Тухайлбал хувь хүний бүтээлч байдал алдагдсанаар ажил сургуулиа хаяж өрхийн орлого буурах, эрүүл мэндэд зарцуулах өртөг зардал нэмэгдэх, үүнийг дагаад хууль эрх зүй, нийгмийн халамж, бусад нийгмийн салбарт зарцуулах нийт зардал давхар нэмэгддэг байна. Тиймээс хүн амын дунд нотолгоонд суурилсан мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүнд цогц тусламж үзүүлэх нэн шаардлагатай байна². Өнөөдөр дэлхий дээр маш олон төрлийн үр дүнтэй эмчилгээний аргууд байгаа боловч, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн цөөхөн хувь нь эмчилгээнд хамрагдаж, тусламж үйлчилгээ авч байна. Жишээлбэл, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй 7 хүн тутмын нэг нь эмчилгээ, тусламж үйлчилгээнд хамрагдаж байна гэсэн тооцоо байна³. Түүнчлэн ДЭМБ-ын тайланд нийт 103 улс оронд хийсэн судалгаанаас харахад 11.9% нь архинд донтох эмгэгтэй байна⁴. Үүнээс харахад архи, мансууруулах хэрэглэх



эмгэгтэй хүмүүсийн эзлэх хувь жилээс жилд ихсэж байгаа боловч эмчилгээ үйлчилгээнд хамрагдах байдал нь хангалтгүй байсаар байна гэжээ.

Манай улсад мансууруулах бодисын хэрэглэгчийг тогтоосон судалгаанууд нэлээдгүй хийгджээ^{5, 6, 7, 8}. Тухайлбал ДЭМБ-ын санхүүжилтээр НЭМГ, Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг (ХТМБИХ) хамтарч ASSISST хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаагаар дэгдэмхий уусгагч бодисын хэрэглээ 5.3% байсан ба сэтгэц идэвхт бодисын хэрэглээ 22% (33) байгаагаас каннабис (8.7%), харин тайвшруулах, нойрсуулах эм (8%) зонхилж байна. Мөн ЕБС-ийн 9-10-р ангийн 1000 сурагчдын дунд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 9% нь мансууруулах бодис хэрэглэж байсан⁹. Судалгааны асуултад 2.9% бензин цавуу, 1.8% каннабис, 0.9% экстази хэрэглэж үзсэн гэж хариулжээ¹⁰. Харин сэтгэгцэд идэвхт эм бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд 2012 онд улсын хэмжээнд 40 тохиолдол бүртгэгдэж байсан 2021 онд 86 буюу 2 дахин нэмэгдсэн байна. 2021 онд сэтгэц идэвхт эм бодисын хэрэглээний улмаас 40 хүн эмчилгээнд хамрагдсан¹¹. Үүнээс гадна СЭМҮТ-ийн 2013 оны Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаагаар архинд донтох эмгэг 6.2% байсан бөгөөд 1986-1992 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад архинд донтох эмгэг 40 дахин ихэссэн байна¹². Дээрх судалгаануудаас харахад мансууруулах бодист донтох эмгэгийн эмчилгээний талаарх хийгдсэн судалгаа харьцангуй цөөхөн, архи, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүс хаана, ямар тусламж үйлчилгээ авч байгаа нь тодорхойгүй нэгдсэн бүртгэлийн системгүй байна. Үүнээс гадна архи, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүст үйлчилгээ үзүүлдэг төрийн болон ТББ байгууллагууд өөр өөрийн гэсэн тайлан мэдээ байгаа боловч эдгээрийг нэгтгэж, суурь тоог гаргадаг тогтолцоо одоог хүртэл бий болоогүй байна.

Гэтэл Монгол улсын ерөнхийлөгчийн 2019 оны 05 сарын 30 өдрийн 104 дүгээр дугаартай зарлигийн 12 ба 13 дугаарт зүйлд Монгол улсын хэмжээнд амиа хорлож нас барсан болон амиа хорлох оролдлого тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болох гэсэн бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” тунхагласан зорилгын 3.5.1-д “Үндэсний хэмжээнд мансууруулах бодис ба архинд донтох эмгэгийн тархалт, эмчилгээний хамралтыг судлах”, 3.4.2-д “Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин” заасан шалгуурыг хангах ажлын хүрээнд 2018-2019 онд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс гаргасан (06/05 тоот зөвлөмж, 1а/2551 албан тоот) үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллах үүргийг биелүүлэхийн тулд энэхүү судалгааны ажлыг хийх хэрэгцээ шаардлага буюу үндэслэл болж байна.

Зорилго:

Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэн, журам боловсруулж, эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах



Зорилтууд:

1. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах стандарт асуумж, маягтыг боловсруулах, батлуулах, нэгдсэн мэдээллийн цахим санг үүсгэх, одоогийн бүртгэлийн маягтын чанарт үнэлгээ, дүгнэлт хийх
2. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг хөтлөх, нэгдсэн сүлжээнд оруулах зэрэг бусад үйл ажиллагаануудыг зохицуулах 4 сайдын (эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй дотоод хэргийн) хамтарсан журам боловсруулах
3. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч зэргийг бүртгэх мэдээллийн санг холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн цахим сүлжээг үүсгэх

Судалгааны ажлын шинэлэг тал:

Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн цахим сүлжээ үүсгэх нь дээрх 2 өвчин эмгэгтэй холбоотой тандалт хяналтын тогтолцоог бий болгож улсын хэмжээнд уг эмгэгүүдийг тархалт өвчлөлийн байдлыг аймаг, дүүргийн хэмжээнд үнэн зөв, давхардалгүйгээр хянаж зохих үйл ажиллагаануудыг цаг алдалгүй төлөвлөх, зохион байгуулах боломжийг бий болгоод зогсохгүй тархалт, өвчлөлийг буурах боломжтой юм.

Санхүүжилт: Эрүүл мэндийг дэмжих сан

Нийт төсөв: 66.185.000 төгрөг



СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

Судалгааны загвар: Уг судалгааны ажлыг аналитик болон чанарын судалгааны нэг агшны загвараар, асуумж болон баримтын судалгааны аргыг ашиглаж 3 үе шаттай хийж байна.

Судалгааны хамрах хүрээ: Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах стандарт асуумж, маягыг боловсруулах, батлуулах, нэгдсэн мэдээллийн цахим санг үүсгэхийн тулд судалгааны асуумжийг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын харьяа болон олон улсын зэрэг бусад нийт 22 байгууллагатай хамтарч судалгаа хийж үр дүнг тооцож анхан шатанд хөтлөгдөх карт болон цахим санд орох өгөгдлүүдийг боловсруулж, 4 яамны хамтарч ажиллах журмын төслийг боловсруулж санал асуулга авч байна. Журам батлагсдын дараа сургалтыг хийнэ.

Хүснэгт 1. Хамтран ажилласан байгууллагуудын нэрс

№	Байгууллагын нэрс
1.	Эрүүл мэндийн яам
2.	Хууль зүй дотоод хэргийн яам
3.	Боловсрол шинжлэх ухааны яам
4.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
5.	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
6.	Нэгдсэн үндэсний байгууллага
7.	Монгол Улсын ерөнхий прокурорын газар,
8.	Монгол улсын үндэсний статистикийн хороо
9.	Эрүүл мэндийн хөгжлийн төв
10.	Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс
11.	Цагдаагийн ерөнхий газрын - Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах хэлтэс
12.	Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс
13.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
14.	Гэмтэл согог судлалын үндэсний төв
15.	Шүүх шинжилгээний ерөнхий газар
16.	Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв
17.	Нийслэлийн эрүүл мэндийн газар
18.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)
19.	Нийслэлийн түргэн тусламж 103
20.	Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
21.	Аддиктологийн төв
22.	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
23.	Хүүхдийн тусламж 108 утас



Арга аргачлал ба хэрэглэгдэхүүн:

I шатанд Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн систем, бүртгэлийн маягт зэргийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний статистикийн хороо зэрэг нэр бүхий 23 байгууллагуудтай хамтран ажиллаж бүлгийн ярилцлага болон баримтын судалгааны арга ашиглаж 2022 оны 08 дүгээр сараас эхэлж 10 сард судалгаа хийсэн.

II шатанд. Нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд үндэслэж Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн нэг системийг хэрхэн бүртгэх, хөтлөх, нэгдсэн сүлжээнд оруулахад дээрх байгууллагууд ямар үүрэгтэй оролцох, нууцлалыг хэрхэн хангах, мэдээллийг нэгтгэж давхардлыг арилгах зэрэг бусад үйл ажиллагаануудыг зохицуулах зохицуулах 4 сайдын (эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй дотоод хэргийн) хамтарсан журмыг 2023 оны 11 сард боловсруулсан.

III. шатанд. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч зэргийг бүртгэх мэдээллийн санг холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн нэг сүлжээг үүсгэх ажлыг 2023 оны 12 сараас эхлэн байгууллага тус бүр өөр өөрийн үүргийн дагуу үйл ажиллагаануудаа явуулна.

Судалгааны нэг дүгээр шатны судалгааны асуумж нийт 4 бүлэг, 231 асуултаас бүрдсэн.

1. Амиа хорлож нас барсан тохиолдлыг бүртгэх маягтыг үнэлэх асуумж – 47 асуулттай
2. Амиа хорлох оролдлогын тохиолдлыг бүртгэх маягтыг үнэлэх асуумж – 58 асуулттай
3. Согтууруулах ундаа хэрэглэгчдийн мэдээллийг бүртгэх маягтыг үнэлэх асуумж – 58 асуулттай
4. Мансууруулах бодис хэрэглэгчдийн мэдээллийг бүртгэх маягтыг үнэлэх асуумж – 68 асуулт

Асуумж боловсруулахад тавигдах шаардлага ба ашигласан эх сурвалж:

Бид Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах олон улсын стандартад нийцсэн бүртгэлийн маягтыг салбар бүрийн онцлогт тохируулж боловсруулж салбар дундын нэгдсэн системийг үүсгэх нөхцөлийн бүрдүүлэхийн тулд бид өнөөгийн байдлыг үнэлэх зорилгоор судалгааны асуумжийг боловсруулсан.

Амиа хорлож нас барсан ба оролдлогын тохиолдлыг бүртгэх маягтыг үнэлэх асуумж, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн үнэлэх, судлах асуумжийг боловсруулахад:

- Дэлхийн тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн холбогдох метадатанд байгаа бүртгэлийн өгөгдлүүд (<https://unstats.un.org/sdgs/metadata/>),
- ДЭМБ-аас жил бүр бүх улс орноос амиа хорлолт болон сэтгэц идэвхт бодис, архины мэдээллийг хүлээж авдаг мэдээллийн санд байгаа бүртгэлийн өгөгдлүүд (<https://www.who.int/data/global-health-estimates>)
- Олон улсад хэвлэгдсэн судалгааны өгүүллүүд
- Монгол улсын эрүүл мэндийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 611 дүгээр бүртгэлийн маягтуудаас бүртгэх маягтыг үнэлэх асуумж, осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33, амиа хорлох тохиолдлыг бүртгэх маягт СЭ-4 маягт, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн бүртгэл СЭ -6 зэрэг олон улсын болон өөрийн орны бүртгэлийн маягтууд байгаа үзүүлэлтүүдийг зэргээс мэдээллийг авч судалгааны асуумжийн 4 картыг боловсруулж судалгаандаа хэрэглэсэн.

Хүснэгт 2. Хамрагдагсдыг судалгаанаас хасах болон оруулах шалгуурууд

Хамруулах шалгуур	Хасах шалгуур
<ul style="list-style-type: none">• Судалгаанд оролцох байгууллага нь улсын хэмжээн дэх тохиолдлуудыг бүртгэж оны эцэст нэгдсэн тайлан гаргадаг байгууллага байна.• Тохиолдлын тоогоо бүртгэх өөрийн гэсэн батлагдсан маягттай байх• Тохиолдлоо бүртгэх салбарын түвшинд мэдээлэл оруулдаг нэгдсэн цахим мэдээллийн сантай байх өөрийн батлагдсан маягттай.• Тохиолдлын тоогоо бүртгэх өөрийн гэсэн батлагдсан маягтгүй байх• Тохиолдлын тоогоо бүртгэх салбарын түвшинд мэдээлэл оруулдаг нэгдсэн цахим мэдээллийн сангүй байх• Байгууллагын удирдлагаа нь таниулсан зөвшөөрөлтэй танилцаж өөрийн алба нэгжийг судалгаанд оролцохыг албан ёсоор зөвшөөрсөн	<ul style="list-style-type: none">• Судалгаанд оролцохоос татгалзсан



Арга аргачлал: Баримтын судалгааны аргыг ашиглаж

Судалгааны арга аргачлалыг дараах 3 үе шаттайгаар явуулсан. Нэгдүгээрт, одоо байгаа эрүүл мэнд болон бусад байгууллагуудын амиа хорлолт, амиа хорлох оролдлого болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэж буй бүртгэлд үнэлгээ хийн бүртгэлийн үндсэн 4 маягт боловсруулсан. Хоёрдугаарт үнэлгээнээс боловсруулсан мэдээллийн өгөгдлийн хоёр үе шаттай Дэльфи аргаар үнэлсэн

Гуравдугаарт, Дэльфи аргаар боловсруулсан асуумжын баталгаат чанарыг үнэлж амиа хорлолт, амиа хорлох оролдлого болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг бүртгэлийн системд үнэлгээ хийж Эрүүл мэндийн байгууллага болон бусад байгууллагуудын бүртгэл мэдээллийн системд оруулах асуумж боловсруулсан.

Асуумжыг цуглуулсан байдал

1. Нэгдүгээр шатнаас боловсруулсан асуумжыг хоёр үе шаттайгаар судалгааны зөвлөх багын гишүүдээс санал авсан.
2. Судалгааны зөвлөх багын гишүүдээс 5 онооны Лайкерт аргаар асуулт тус бүрийн ач холбогдолыг үнэлүүлсэн.
3. Асуултыг үнэлэхдээ нь "хамгийн бага ач холбогдол"-ыг илтгэх нэгээс "хамгийн чухал ач холбогдолтой" буюу тав хүртэл оноогоор үнэлсэн. Эцэст нь тухайн оролцогчийн чухал гэж үзэж буй асуумжид тусгагдаагүй зүйлсийг оролцогч тус бүрээс авсан.

Судалгааны шинжээчдийн зөвлөлийг сонгосон байдал.

Дельфийн судалгаанд нэгэн төрлийн байдал, судалгааны үргэлжлэх хугацаа, хамрах хүрээ, мэргэжилтнүүдийн хүрэлцээ, судалгааны зорилго зэргийг үндэслэн шинжээчдийн зөвлөлийг **нийт 12 байгууллагын 16 хүнтэй багийг бүрдүүлсэн. Үүнд:**

1. Эрүүл мэндийн яамнаас – 1 хүн
2. Хууль зүй дотоод хэргийн яамнаас -1 хүн
3. Боловсрол шинжлэх ухааны яамнаас - 2 хүн
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас - 2 хүн
5. Монгол Улсын ерөнхий прокурорын газар- 1 хүн
6. Монгол улсын үндэсний статистикийн хороо – 1 хүн
7. Эрүүл мэндийн хөгжлийн төв – 2 хүн
8. ЦЕГ -Хар тамхитай тэмцэх хэлтэс -1 хүн
9. ЦЕГ- Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс – 1 хүн
10. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс - 2 хүн
11. АШУҮИС-ийн сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим -1 хүн
12. Шүүх шинжилгээний ерөнхий газраас – 1 хүн

Мэргэжилтнүүдийг сонгохдоо дараахь хүчин зүйлсийг анхаарч үзсэн. Үүнд: Судалгааны зорилгын дагуу холбогдох салбаруудыг мэргэжилтнүүдийг сонгохдоо тухайн мэргэжлээрээ



хоёроос дээш жил ажилласан туршлагатай, холбогдох эрдмийн болон мэргэжлийн зэрэгтэй цолыг харгалзаж сонгосон.

Дельфи шат: Оролцогчид үнэлгээ өгөх, зөвлөмж өгөх, асуумжын ач холбогдолыг сонгохын тулд санал асуулгыг цаасаар явуулсан. Тухайн өгөгдлийн ач холбогдолыг оролцогчдын 60%-с бага хувь нь ач холбогдолтой гэж үзсэн өгөгдлүүдийг хассан бол 75%- хувиас дээш санал авсан өгөгдлүүдийг маягт боловсруулахад агшилсан.

Судалгааны ажлын ёс зүй:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн 2023 оны 09 дугаар сарын 19 өдрийн №2 дугаартай хурлаар сэдэв аргачлалыг батлуулсан.
2. ЭМЯ-ны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 10 сарын 13-ны өдрийн хурлаар орж судалгааны ажлын арга, аргачлал, таниулсан зөвшөөрөлтэй холбоотой ёс зүйн асуудлыг хэлэлцүүлж судалгааны ажлыг явуулах ёс зүйн зөвшөөрлийг 2023 оны 10 сарын 13-ны өдрийн 23/050 дугаартай тогтоолоор авсан.
3. Судалгаанд оролцогч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан нарт судалгааны зорилгыг нэг бүрчлэн таниулж судалгаанд өөрийн хүсэлтээр оролцох, мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглахыг тайлбарлан ойлгуулсан. Судалгаанд оролцогч байгууллагын болон хувь хүний нууцыг чандлан хадгалж, судалгааны үр дүнг хэвлэн нийтлэхэд байгууллагын болон хувь хүний нэрийг дурдахгүй. Судалгааны үр дүнг зөвхөн тухайн судалгаанд ашиглах бөгөөд өөр зориулалтаар ашиглахгүй байх болно.
4. Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, кибер аюулгүй байдлын тухай хуулиудын зохих зүйл заалтуудад заасан албан байгууллага болоод хувь хүний нууцын зэрэглэлтэй мэдээллүүдийг хамгаалах, хуулийн зохих заалтуудыг баримталж ажилласан бөгөөд цаасан мэдээллүүдийг хавтасжуулан баримтжуулж хадгалсан. Судалгааны хавтасжуулсан материалыг судалгааны багийн гишүүдээс өөр хүнд шилжүүлээгүй.
5. Судалгааны явцад судалгаанд оролцохоос татгалзсан байгууллага байхгүй.
6. Судалгааны мэдээллийг хэвлэн нийтлэхэд байгууллага болон хүний нэрийг дурдахгүй, мэдээллийг зөвхөн тухайн судалгаанд ашиглах бөгөөд өөр зориулалтаар ашиглахгүй байх болно.
7. Судалгааны ажлыг дууссаны дараа ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар ЭМЯ-ны Ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

Статистик боловсруулалт: Судалгааны материалыг Microsoft Excel программ ашиглан ихэнх үр дүнг илэрхийлэх ба график дүрслэл, хүснэгтийг хийж, шаардлагатай тохиолдолд SPSS 25.0 программаар давхардсан болон дутуу өгөгдөлд үнэлгээ хийнэ. Агуулгын хүчинтэй байдлын индекс (АХБИ)-ийг тодорхойлоно. Энэ алхамд хэлэлцүүлэгт оролцогчдоос амиа хорлолт, амиа хорлох оролдлого болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэлийн асуулгад оруулах асуумжын талаархи үнэлгээг авах. АХБИ -г тооцоолохын тулд оролцогчид бүртгэлийн асуумжид тусгагдсан асуулт тус бүрийг ач холбогдлоор үнэлэх. Төвийг сахисан үзэл бодлыг үгүйсгэхийн тулд 1-ээс 4 хүртэлх (1 = чухал биш, 2 = заримдаа чухал, 3 = чухал, 4 = маш чухал) оноотой Лайкерт үнэлгээг ашигласан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

НЭГ ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН:


Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн систем, бүртгэлийн маягт зэргийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах ёс зүйн зөвшөөрлийг авч бүлгийн ярилцлага болон баримтын судалгааны арга ашиглаж 2022 оны 10 дүгээр сараас эхэлж 11 сард судалгаа хийсэн.

Бид судалгаанд оролцогч байгууллагуудаас оролцогч нараас амиа хорлох ба архи мансууруулах бодисын шалтгаант хэрэглээ ба донтолтын тохиолдлуудыг бүтгэхэд хүн ам зүйн үзүүлэлтүүдийг бөглөх боломжтой эсэх, тухайн хүн ам зүйн мэдээлэл нэгдсэн сан үүгэхэд тухайн үзүүлэлтүүдийг оруулах хэрэгцээ шаардлага бий эсэх талаар санал асуулга авахад оролцогчдын 85- 100 хувийн саналаар хүн ам зүйн ерөнхий мэдээллийг оруулах боломжтой, бүртгэлийн маягтад оруулах санал өгсөн. Уг мэдээллийг “Хур” цахим сангаас шууд татагдах боломжтой гэсэн саналыг 100 хувь дэмжигдсэн. Тиймээс бид хүн ам зүйн ерөнхий мэдээллүүдэд өгсөн саналуудыг амиа хорлох ба архи мансууруулах бодисын шалтгаант хэрэглээ ба донтолтын гэсэн 2 бүлэгт хувааж Зураг 1 ба 2-оор харууллаа.



Зураг 1. Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “Хүн ам зүйн мэдээлэл” –д өгсөн санал


Зураг 1-ээс харахад амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд тухайн хүний регистрийн дугаар, нас хүйс, төрсөн он сар өдөр, гэрлэлтийн байдал, мэргэжил, амьдардаг газрын хаяг, боловсрол зэрэг үзүүлэлтүүдийг судалгаанд оролцогч байгууллагууд бүгд бөглөх боломжтой ба эдгээр мэдээллүүдийг “Хур” цахим системээс татаж авах бүрэн боломжтой гэж хариулсан бол Уг үйлдлийг хийх болсон шалтгааныг тодорхойлоход нас барсан тохиолдолд үнэлэхэд хэцүү гэж 22.2 хувь нь хариулсан бол оролдлого хийсэн тохиолдолд 95% нь шалтгааныг тогтоох боломжтой гэж хариулжээ. Харин амиа хорлож нас барсан тохиолдолд шилжүүлсэн газрыг бөглөх нь ач холбогдол багатай гэж 50 хувь нь санал өгсөн тул уг үзүүлэлтүүдийг нас барсан тохиолдлыг бүртгэх маягтаас хасах санал дээр санал нэгдсэн.



Зураг 2. Архи мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Хүн ам зүйн мэдээлэл” –д өгсөн санал

Зураг 2-оос харахад архи, мансууруулах бодис хэрэглээ ба донтох эмгэгтэй тохиолдлыг бүртгэхэд тухайн хүний регистрийн дугаар, нас хүйс, төрсөн он сар өдөр, гэрлэлтийн байдал, мэргэжил, амьдардаг газрын хаяг, боловсрол зэрэг үзүүлэлтүүдийг судалгаанд оролцогч байгууллагууд бүгд бөглөх боломжтой ба эдгээр мэдээллүүдийг “Хур” цахим системээс татаж авах бүрэн боломжтой гэж хариулсан бол бэлгийн чиг баримжааг үнэлэх асуумжийг мансууруулах бодисын хэрэглээ ба донтолтын 22 хувь нь, архинд донтох эмгэгийн 65 хувь нь


үнэлэх боломжтой гэж хариулсан байна. Иймд судалгааны маягтаас бэлгийн чиг баримжааг үнэлэх үзүүлэлтийг асуумжаас хассан.



Зураг 3. Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “Нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд” –д өгсөн санал


Зураг 3-аас харахад нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдээс хамгийн ач холбогдол бүхий мэдээллүүдэд амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд ам бүлийн тоо (98%), хэнтэй амьдардаг (88%), архи (93%), тамхины (96%) хэрэглээ, ганцаараа амьдардаг эсэх (90%), гэр

бүл (81%), нийгэм олон нийтийн (87%), ажлын байр дээр(81%) ямар нэгэн харилцааны зөрчилтэй байсан эсэх, хууль зүйн асуудалтай эсэх (87%) зэрэг үзүүлэлтүүд илүү ач холбогдол өндөртэй байгаа бол амиа хорлож нас барсан тохиолдолд ам бүлийн тоо (75%), хэнтэй амьдардаг (78%)хууль зүйн асуудалтай эсэх (80%), архи (75%) , тамхины (76%) хэрэглээ, ганцаараа амьдардаг эсэх (78%), гэр бүл (75%)-д ямар нэгэн харилцааны зөрчилтэй байсан эсэх зэрэг үзүүлэлтүүд бусад үзүүлэлтүүдээсээ илүү ач холбогдол бүхий байсан



Зураг 4. Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “Эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүд” –д өгсөн санал

Зураг 4-өөс харахад эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүдээс хамгийн ач холбогдол бүхий мэдээллүүдэд амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд Бие- сэтгэцийн талаас ямар нэгэн өвчин, эмгэгтэй байсан эсэх (90%), хүчирхийлэлд өртөж байсан эсэх (97%), ялангуяа бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэх (95%), хэн нэгний дарамтад байсан эсэх (87%) зэрэг үзүүлэлтүүд орж байхад амиа хорлож нас барсан тохиолдолд Бие- сэтгэцийн талаас ямар нэгэн өвчин, эмгэгтэй байсан эсэх (75%), бие махбодын хүчирхийлэлд өртсөн эсэх (80%) зэрэг үзүүлэлтүүд бусад үзүүлэлтүүдээс илүү ач холбогдол бүхий байсан.




Зураг 5. Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд шаардлагатай “нөхцөл байдлын үнэлгээний үзүүлэлтүүд” –д өгсөн санал

Зураг 5-аас харахад амиа хорлох нөхцөл байдлыг үнэлэх дараах:

- Өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан эсэх
- Өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан бол огноонуудыг бичих
- Амиа хорлож нас барсан эсвэл оролдлого хийсэн ...он ... сар ... өдөр цаг бичих
- Амиа хорлож оролдлого хийсэн долоо хоногийн гаригийн сонгох
- Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн газар
- Амиа хорлож нас барсан арга зэрэг үзүүлэлтүүд нь бүгд амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд болон амиа хорлож нас барсан тохиолдлыг бүртгэхэд хамгийн өндөр ач холбогдол бүхий мэдээллүүдэд тул бүртгэлийн маягтад оруулах зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна.


Дээрх судалгааны үр дүнд тулгуурлаж бид “Амиа хорлож нас барсан” тохиолдлыг хүмүүсийг бүртгэхээр боловсруулсан 45 үзүүлэлт бүхий маягтаас ач холбогдол багатай үзүүлэлтүүдийг хасалт хийж Эрүүл мэндийн салбарт бүртгэх маягтыг 28 үзүүлэлтэй, Эрүүл мэндийн бус салбарт бүртгэх маягтыг 27 үзүүлэлт бүхий 2 маягт боловсруулсан. Харин амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийг бүртгэхээр боловсруулсан 58 үзүүлэлт бүхий маягтаас ач холбогдол багатай үзүүлэлтүүдийг хасалт хийж Эрүүл мэндийн салбарт бүртгэх маягтыг 33 үзүүлэлт, Эрүүл мэндийн бус салбарт бүртгэх маягтыг 30 үзүүлэлт, бүх шатны боловсролын салбарт бөглөх маягтыг 16 нь үзүүлэлт бүхий 3 маягтыг тус тус боловсруулсан. (нийт 5 маягтыг Хавсралт 1-ээс үзнэ үү?)

Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд болон бусад үзүүлэлтүүдэд хийсэн судалгааны үр дүн



Зураг 6. Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Өсөж бойжсон гэр бүлийн талаарх асуумж” –д өгсөн санал


Зураг 6-аас харахад Өссөн гэр бүлийн ам бүлийн тоо, хүмүүжлийн хэлбэр, эцэг, эх архи, мансууруулах бодисын хамааралтай эсэх, гэр бүлд сэтгэцийн эмгэгтэй хүн байдаг эсэх гэр бүлд амиа хорлож байсан хүнтэй эсэх, гэр бүлд сэтгэц нөлөөт бодисын хэрэглээтэй эсвэл донтолттой хүн байдаг эсэх гэсэн үзүүлэлтүүд нь бүгд 80-аас дээш хувьтай ач холбогдол өндөртэй асуумжууд байсан хэдий ч ажлын хэсгийн гишүүдээс маягт нь бөглөж буй мэргэжилтнүүдэд хялбар байлгах үүднээс аль болох цомхон байх хэрэгтэй гэсэн дийлэнх олонхын саналыг үндэслэж тухайн хүний удамд нь архи, мансууруулах бодисын хамааралтай хүн байсан эсэхийг үнэлэх асуумжийг маягтайнд оруулахаар сонгосонб



Зураг 7. Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Эрүүл мэндийн байдлыг үнэлэх үзүүлэлт” –д өгсөн санал

Зураг 7-оос харахад Архаг хууч өвчинтэй эсэх, бэлгийн замын халдварт өвчнөөр өвдөжбайсан эсэх, анх удаа шинээр бүртгэгдсэн тохиолдлыг идэвхтэй хяналтад авсан эсэх, давтан оношлогдож байгаа тохиолдол нь идэвхтэй хяналтад байдаг эсэх, анх хэдэн насанд хэрэглэж эхэлсэн эсэх, нийт хэрэглэсэн жил хэрэглэж байгаа, хүчирхийлэлд өртсөн эсэх зэрэг асуултууд нь ач холбогдол бүхий өндөр саналтай байсан тул бид бүртгэлийн маягтад нэгтгэж тусгасан болно.


Гэмт хэрэгт холбогдож байсан талаарх асуумж



Зураг 8. Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Гэмт хэрэгт холбогдож байсан талаарх асуумж” –д өгсөн санал

Зураг 8-аас харахад хэрэглэсэн үедээ хэрэгт холбогдсон эсэх, эд хөрөнгөө зарж, ломбардад тавьж, зээл авч, хулгай хийж архи авч ууж байсан эсэх, архи, сэтгэц нөлөөт бодис, тамхи зэргийг хавсарч хэрэглэдэг эсэх, сэтгэцийн эмчийн хяналтад байдаг эсэх, шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээнд орсон эсэх, архины албадан эмчилгээнд хамрагдаж байсан эсэх зэрэг үзүүлэлтүүд илүү ач холбогдолтой өндөр гарсан. Иймд эдгээр асуултуудыг эрүүл мэндийн болон бусад байгууллагуудын маягтын бөглөх үзүүлэлтүүдэд оруулах шаардлагатай байна.

Эмчилгээний төрөл ба хийгдсэн эмчилгээний түүхийг үнэлэх



Зураг 9. Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Эмчилгээний төрөл ба хийгдсэн эмчилгээний түүхийг үнэлэх” –д өгсөн санал

Зураг 9-өөс харахад архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд шаардлагатай “Эмчилгээний төрөл ба хийгдсэн эмчилгээний түүхийг үнэлэх үзүүлэлтүүд болох Хордлого тайлах эмчилгээ хийлгэж байсан эсэх, өвөрмөц эмчилгээ хийлгэсэн эсэх, хор хөнөөлийн талаарх сургалтад хамрагдсан эсэх, сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан эсэх, нийгмийн нөхөн сэргээх (нийгэмшүүлэх) тусламжид хамрагдсан эсэх, өөртөө туслах бүлэгт явдаг эсэх зэрэг үзүүлэлтүүд нь ач холбогдолтой өндөр үнэлэгдсэн. Иймд эдгээр асуултуудыг эрүүл мэндийн болон бусад байгууллагуудын маягтын бөглөх үзүүлэлтүүдэд оруулах шаардлагатай байгааг харууллаа.

Бид дээрх судалгааны үр дүнд тулгуурлаж “архи согтууруулах удааны хэрэглээтэй холбоотой үүсэх эмгэгтэй хүмүүсийг бүртгэхээр боловсруулсан 58 үзүүлэлт бүхий маягтаас ач холбогдол багатай үзүүлэлтүүдийг хасалт хийж Эрүүл мэндийн салбарт бүртгэх маягтыг 21 үзүүлэлтэй, Эрүүл мэндийн бус салбарт бүртгэх маягтыг 27 үзүүлэлт бүхий 2 маягт боловсруулсан. Харин мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой үүсэх эмгэгтэй хүмүүсийг бүртгэхээр боловсруулсан 68 үзүүлэлт бүхий маягаас ач холбогдол багатай үзүүлэлтүүдийг хасалт хийж Эрүүл мэндийн салбарт бүртгэх маягтыг 22 үзүүлэлт, Эрүүл мэндийн бус салбарт бүртгэх маягтыг 31 үзүүлэлт бүхий 2 маягт боловсруулсан бол архи, мансууруулах бодисын хэрэглээтэй хүүхдийг бүх шатны боловсролын салбарт бүртгэх маягтыг 15 нь үзүүлэлт бүхий 1 маягтыг тус тус боловсруулсан. (нийт 5 маягтыг Хавсралт 2-оос үзнэ үү.)



СУДАЛГААНЫ НЭГ ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮГНЭЛТ

Бид судалгааны явцад ажлын хэсгийн гишүүдээс гаргасан “маягт нь бөглөж буй мэргэжилтнүүдэд хялбар байлгах үүднээс аль болох цомхон байх хэрэгтэй” гэсэн саналыг үндэслэж анх боловсруулсан бүртгэлийн маягтаас ач холбогдол багатай, ажлын гишүүдийн 75-аас дээш санал авч чадаагүй үзүүлэлтүүдийг ач холбогдол багатай гэж үнэлж хасалт хийж бүртгэлтийн маягтын загварыг

1. Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэх,
2. Амиа хорлож нас барсан тохиолдлыг бүртгэх,
3. Архинд донтогчийг бүртгэх
4. Мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх гэсэн Үндсэн 4 сэдэв тус бүрд нь
 - Эрүүл мэндийн салбарт бүртгэх (4 нь маягт)
 - Эрүүл мэндийн бус салбарт бүртгэх (4 нь маягт)
 - Бүх шатны боловсролын салбарт бүртгэх (2 маягт) гэсэн 3 нь ангиллаар нийт 10 маягт боловсруулсан. (Хавсралт 1 ба 2-оос үзэх)

СУДАЛГААНЫ ХОЁР ДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН:

Бид нөхцөл байдлын үнэлгээг дараах нэр бүхий 14 байгууллагуудтай хамтран ажиллаж Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг цахим программууд болон бүртгэлийн маягуудтай мэдээлэл солилцсон. Үүнд:

Хамтран ажилласан байгууллагын нэрс

1. Эрүүл мэндийн хөгжлийн төв
2. Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс
3. Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс
4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
5. Гэмтэл согог судлалын үндэсний төв
6. Шүүх шинжилгээний ерөнхий газар
7. Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв
8. Нийслэлийн эрүүл мэндийн газар
9. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)
10. Нийслэлийн түргэн тусламж 103
11. Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
12. Аддиктологийн төв
13. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
14. Хүүхдийн тусламж 108 утас



Хүснэгт 3. Амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдлыг бүртгэхэд ашиглаж буй бүртгэлийн маягт ба цахим программын мэдээлэл

Одоо ашиглабүртгэлийнж байгаа			
№	Байгууллагын нэрс	Маягтын нэр	Цахим программын нэр
1.	Эрүүл мэндийн хөгжлийн төв	Нас баралт -AM-7 Оролдлого AM-33	H-info
2.	Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс	Мэдээлэл өгөөгүй	
3.	Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс	Нас баралтыг - Гэмт хэргийн бүртгэл Оролдлого – бүртгэл байхгүй	Дотоодын цахим системд
4.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	СЭ-1, СЭ-4, СЭ-5	H-info
5	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Нас баралт -AM-7 Оролдлого AM-33	H-info
6	Шүүх шинжилгээний ерөнхий газар	Нас баралт -AM-7	H-info
7	Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв	Мэдээлэл өгөөгүй	
8.	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Нас баралт -AM-7 Оролдлого AM-33	H-info
9.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)	Нас баралт -AM-7 Оролдлого AM-33	H-info
10	Нийслэлийн түргэн тусламж 103	ЭМС А/611 тоот тушаал	medsoft
11	Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв	Нас баралт -AM-7 Оролдлого AM-33	Karte.mn
12	Аддиктологийн төв	Мэдээлэл өгөөгүй	
13	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	Зөвлөгчийн бүртгэлийн маягт	Цахим программ байхгүй, SPSS
14	Хүүхдийн тусламж 108 утас	Мэдээлэл өгөөгүй	

Хүснэгт 3-аас харахад СЭМҮТ-өөс бусад эрүүл мэндийн байгууллагууд нь амиа хорлож нас барсан тохиолдлыг ЭМС А/611 тоот тушаалын AM-7 маягтаар, оролдлого хийсэн тохиолдлыг AM-33 маягтаар бүртгэхдээ H-info, Karte.mn, Karte.mn зэрэг өөр цахим программ ашиглаж байна. Энэ нь мэдээлэл нэг урсгалаар орохгүй байгааг харуулж байгаа бөгөөд мэдээлэл үнэн бодит байх магадлалыг бууруулах магадлалтай байна. Харин Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс нь холбогдох цагдаагийн бүх байгууллагуудаасаа амиа хорлож нас барсан тохиолдлыг гэмт хэргийн бүртгэл гэсэн нэртэй маягтаар цагдаагийн цахим сангаараа бүртгэдэг бол оролдлого хийж буй тохиолдлыг огт бүртгэдэггүй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа



Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүүхдийн тусламж 108 утас зэрэг байгууллагууд нь зөвхөн амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийн мэдээллийг Зөвлөгчийн бүртгэлийн маягт нэртэй дотоодын маягтаараа бүртгэж, SPSS программ ашиглаж байгууллагын хэмжээнд ашигладаг байна. Эндээс дүгнэхэд судалгаанаас харахад амиа хорлож нас барсан ба оролдлого хийсэн тохиолдол нь Эрүүл мэнд, Хууль зүй, Хөдөлмөр нийгэм хамгааллын яамдаас судалгаанд оролцож байгаа бүх байгууллага дээр бүртгэдэг нийтлэг дүр зураг байгаа боловч эдгээр тоо мэдээнүүдийг нэгтгэж давхардлыг арилгаж үндэсний статистикийн хороонд мэдээлдэг тогтолцоо байхгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 4. Архи, мансууруулах бодисын шалтгаант эмгэгүүдийг бүртгэхэд ашиглаж буй бүртгэлийн маягт ба цахим программын мэдээлэл

Одоо ашиглаж бүртгэлийнж байгаа			
№	Байгууллагын нэрс	Маягтын нэр	Цахим программын нэр
1.	Эрүүл мэндийн хөгжлийн төв	AM-7	H-info
2.	Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс	Тусгай дотоодын бүртгэлтэй	Гадагш нь мэдээлдэггүй
3.	Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс	Эрүүлжүүлэх саатуулах хүн	Саатуулагдсан хүний бүртгэл
4.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	СЭ-6	H-info
5.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Нас барсан тохиолдолд -AM-7	H-info
6.	Шүүх шинжилгээний ерөнхий газар	Мэдээлэл өгөөгүй	
7.	Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв	Мэдээлэл өгөөгүй	
8.	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Нас барсан тохиолдолд -AM-7	H-info
9.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)	Мэдээлэл өгөөгүй	
10.	Нийслэлийн түргэн тусламж 103	ЭМС А/611 тоот тушаал	medsoft
11.	Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв	Мэдээлэл өгөөгүй	
12.	Аддиктологийн төв	Мэдээлэл өгөөгүй	
13.	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	Зөвлөгчийн бүртгэлийн маягт	Цахим программ байхгүй, SPSS
14.	Хүүхдийн тусламж 108 утас	Мэдээлэл өгөөгүй	



Хүснэгт 4-оос харахад СЭМҮТ- нь ЭМС А/611 тоот тушаалын СЭ 6 буюу “МАНСУУРУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭХ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ” нэртэй нэг маягтаар бүртгэл хийж байгаа бөгөөд архинд донтох эмгэгийг бие даасан маягтаар бүртгэх боломжгүй байна. Нөгөө талаас СЭМҮТ-өөс бусад эрүүл мэндийн байгууллагууд нь архи мансууруулах бодисын шалтгаант эмгэгээр нас барсан тохиолдолд нас барсан тохиолдлыг бүртгэдэг ЭМС А/611 тоот тушаалын АМ-7 маягтаар амиа хорлож нас барсан хүний бүртгэлтэй нэг ижил маягтаар бүртгэж байна. Харин хуулийн байгууллага Эрүүлжүүлэх саатуулах хүн маягтаар, хар тамхитай тэмцэх хэлтэс нь мансууруулах бодисын хэрэглээтэй хүмүүсийг тус тус дотоодоо бүртгэл хийж байгаа боловч нэгдсэн тайлан мэдээ өгдөг цахим систем байхгүй байна. Гэтэл архи, мансууруулах бодисын хэрэглээ нь дэлхий нийтийн өмнө эрүүл мэнд, нийгэм хамгаалал, боловсрол, хууль хүчний байгууллагуудын тулгамдсан асуудал болсныг бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” тунхагласан зорилгын 3.5.1-д “Үндэсний хэмжээнд мансууруулах бодис ба архинд донтох эмгэгийн тархалт, эмчилгээний хамралтыг судлах мэдээлэх үүргийг улс орон бүрд өгсөн баталж байна. Гэтэл манай улс нь энэхүү “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” зорилтыг бүрэн гүйцэд биелүүлэх мэдээллийн нэгдсэн сан болон бүртгэлийн шаардлага хангасан маягт өнөөг хүртэл огт байхгүй байгаа нь харагдаж байна.

Мөн Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг салбар дундын нэгдсэн нэг систем өнөөг хүртэл байхгүй байна. Гэтэл дээрх хоё бүлэг асуудлууд нь нийгэм, эрүүл мэнд, хууль, боловсрол гэсэн үндсэн 4 том салбарын дундын тулгамсан асуудал болохыг энэхүү судалгааны нэг хоёдугаар шатны судалгааны үр дүнгээс гадна олон улсад болон Монгол хийгдсэн судалгаануудын үр дүн харуулж байна. Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг салбар дундын нэгдсэн нэг системийг бий болгоход Монгол улсын Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, шинжлэх ухааны яамдын хамтын оролцоо нэн түрүүнд шаардлагатай байна. “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг салбар дундын нэгдсэн нэг системийг бий болгоход” нэн түрүүнд Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаал гаргах шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ХОЁР ДУГААР ЗОРИЛТЫН ДҮГНЭЛТ:

Бид нөхцөл байдлын үнэлгээг дараах бүртгэл мэдээлэл хийдэг гэсэн нэр бүхий 14 байгууллагуудтай хамтран ажилласан. Үүнд:

Эрүүл мэндийн салбараас:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төв
2. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
3. Гэмтэл согог судлалын үндэсний төв
4. Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв
5. Нийслэлийн эрүүл мэндийн газар
6. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл) 7. Нийслэлийн түргэн тусламж 103



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



8. Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
9. Аддиктологийн төв

Хууль зүй, дотоод хэргийн салбараас:

10. Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс
11. Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс
12. Шүүх шинжилгээний ерөнхий газар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас

13. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
14. Хүүхдийн тусламж 108 утас

Харин Боловсрол, шинжлэх ухааны салбарт ямар нэгэн бүртгэл мэдээлэл хийдэггүй гэсэн хариулт өгсөн.

Судалгааны нэг дүгээр зорилтоос гарсан 4 ангилал бүхий 10 маягтаар дээрх байгууллагуудын хүрээнд судалгаа хийхэд.

1. Эрүүл мэнд,
2. Хууль зүй, дотоод хэрэг,
3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал,
4. Боловсрол, шинжлэх ухаан гэсэн үндсэн 4 салбар хамтарсан журам боловсруулж гаргах нь зүйлтэй гэсэн дүгнэлт гарсан.

Иймд бид 4 салбарын хамтарсан **“Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай”** нэртэй 19 хуудас бүхий журам боловсруулсан. (Хавсралт 3-аас үзэх)

СУДАЛГААНЫ ГУРАВ ДУГААР ЗОРИЛТЫН ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ:

1. Тус шатны судалгааны үйл ажиллагаа дөнгөж эхлээд явж байгаа тул үр дүн арайхан гүйцэд гаргаагүй байна. Учир нь бид Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч зэргийг бүртгэх мэдээллийн санг холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн нэг сүлжээг үүсгэх ажлыг 2023 оны 12 сараас эхлэн 3 сарын хугацаанд үргэлжлэхээр төлгөлгөөтэй ажилласан
2. Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл хийхэд оролцох бүх байгууллагууд нэг ижил нэр томъёог баримтлах үүднээс бид мэдээллийн тогтолцоонд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг боловсруулсан. (Хавсралт 4)
3. 2024 сарын 3 сард Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 4 салбарын хамтарсан **“Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай”** тушаалын төслийг Засгийн газрын тогтоол гаргуулах нь зүйтэй гэсэн саналыг өгч СЭМҮТ-ийг амиа хорлолтой



холбоотой нэгдсэн үүсгэхэд анхаарч ажиллах санал өгөх үүрэг өгсний дагуу ажлын хэсэг ажиллаж 1 хуудас саналыг боловсруулж 2024 оны 04 сарын 04 өдөр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд хүргүүлсэн. (Хавсралт 5)

Тиймээс бид судалгааны хоёр дугаар шатанд боловсруулсан Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч зэргийг бүртгэх мэдээллийн санг холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн нэг сүлжээг үүсгэхээр Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яамны холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлуудыг хийгээд явж байна.

Мөн дээрх үндсэн 4 салбар хамтарч боловсруулсан **“Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай”** нэртэй 4 сайдын тушаалыг батлуулах эсвэл Засгийн газрын тогтоол гаргуулж нэгдсэн санг бий болгох, эх серверээр хангах, холбох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн яамны “Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтэс” удирдлагаар хангаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ЭММА-ны Мэдээллийн технологийн алба уялдуулах ба удирдаж чиглүүлж ажиллах, СЭМҮТ-ийн статистик тандалт судалгааны алба мэдээ тайланг нэгтгэх, давхцалыг арилгах, мэдээлж, хэрэгжүүлж ажиллах үүрэг тус тус хүлээгээд ажиллаж байна.

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Бид “Амиа хорлох оролдлого хийсэн, хорлож нас барсан тохиолдол, архинд донтох эмгэг ба мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч”-ийг бүртгэх гэсэн 4 сэдвийн хүрээнд эрүүл мэндийн салбарт (4 нь маягт), эрүүл мэндийн бус салбарт (4 нь маягт), бүх шатны боловсролын салбарт (2 маягт) бүртгэх гэсэн 3 нь ангиллаар нийт 10 маягт боловсруулсан. (Хавсралт 1-2)
2. Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, шинжлэх ухаан гэсэн үндсэн 4 салбарын хамтарсан **“Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай”** нэртэй 19 хуудас бүхий журам ба нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг боловсруулсан. (Хавсралт 3-4)
4. **“Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай”** нэртэй Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, шинжлэх ухааны салбарын 4 сайдын тушаал батлуулах эсвэл Засгийн газрын тогтоол гаргуулж нэгдсэн санг бий болгох, эх серверээр хангах, холбох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн яамны “Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтэс” удирдлагаар хангаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ЭММА-ны Мэдээллийн технологийн алба уялдуулах ба удирдаж чиглүүлж ажиллах, СЭМҮТ-ийн статистик тандалт судалгааны алба мэдээ тайланг нэгтгэх, давхцалыг арилгах, мэдээлж, хэрэгжүүлж ажиллах үүрэг тус тус хүлээгээд ажиллаж байна. Мөн Засгийн газрын тогтоол гаргуулах талаар СЭМҮТ-өөс амиа хорлолтой холбоотой нэгдсэн үүсгэхэд анхаарч ажиллах саналыг боловсруулж 2024 оны 04 сарын 04 өдөр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд хүргүүлсэн. (Хавсралт 5)



Ном зүй:

1. <http://www.who.int/gho/en/> (ДЭМБ-ын үзүүлэлтийн тодорхойлолт)
2. (http://apps.who.int/gho/indicatorregistry/App_Main/view_indicator.aspx?iid=4664)
(Дэлхий даяар нас баралтын шалтгааны талаарх ДЭМБ-ын арга, 2000–2019 он)
3. (https://www.who.int/docs/default-source/gho-documents/global-health-estimates/ghe2019_cod_methods.pdf) (Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейн тогтоол WHA66.8 (2013): Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны 2013-2020 он хүртэлх үйл ажиллагааны иж бүрэн төлөвлөгөө)
(http://apps.who.int/gb/ebwha/pdf_files/WHA66/A66_R8-en.pdf?ua=1)
4. <https://wdr.unodc.org/wdr2019/>
5. McLellan A. T. (2017). Substance Misuse and Substance use Disorders: Why do they Matter in Healthcare?. Transactions of the American Clinical and Climatological Association, 128, 112–130
6. United Nations International Drug Control Programme., United Nations Office for Drug Control and Crime Prevention., & United Nations Office on Drugs and Crime. (2019). World drug report.
7. https://www.who.int/healthinfo/global_burden_disease/about/en/
8. ХЗДХЯ, МУГХУСАЗЗ, Дэлхийн зөн Монгол ОУБ, Өсвөр үеийнхний дундах мансууруулах бодисын хэрэглээ, хор хөнөөлийн талаарх мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа, 2011
9. НГХУСАЗЗ, Нийслэлийн өсвөр үе, хүүхэд залуучуудын дунд мансууруулах сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисын хэрэглээ, ойлголтын талаарх тандалт судалгаа, УБ хот, 2010 он
10. Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодис хэрэглэгчдийн хэрэглээ, тэдний мэдлэг, хандлага, хор уршгийн талаарх тандалт судалгаа, 2012 он
11. НЭМҮТ, ХТМБИХН, Улаанбаатар хотын мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд ХДХВ/ДОХ-ын халдварын эрсдлийг үнэлэх судалгаа, УБ, 2014 он
12. Ш.Лхагвасүрэн. Монголын өсвөр үеийнхнийг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх ажлын агуулга, арга зүй, УБ, 2009 он
13. Нийслэлийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Зөвлөл. Нийслэлийн өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын хэрэглээ ойлголтын талаарх тандалт судалгааны тайлан, УБ, 2010 он
14. СЭМҮТ-ийн статистик тайлан мэдээ, УБ, 2021 он
15. СЭМҮТ, Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаа, УБ, 2013 он.



ХАВСРАЛТ 1

ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын оны
..... сарын өдрийн...дугаар
тушаалын гурав дугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагад хөтлөгдөх маяг

АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО ХИЙСЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ МАЯГТ

А	Д	Эцэг /эх/-ийн нэр, Өөрийн нэр Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар	Он сар өдөр
1	2	Цаг, минут	
	3	Долоо хоногийн гаригийн нэрийг бичих	
	4	Амиа хорлох үйлдэл хийсэн газар	
	5	Нас	
	6	Хүйс	
	7	Боловсрол /код/	
	8	Мэргэжил	
	9	Хөдөлмөр эрхлэлтийн байдал /код/	
	10	Хөдөлмөр эрхлэггүй шалтгаан /код/	
	11	Гэрлэлтийн байдал /код/	
	12	Тогтмол хаяг	
	13		
	14	Хүчирхийлэлд өртсөн эсэх (тийм-1, үгүй-2)	
	15	Хүчирхийллийн хэлбэр Үл хайхрах хүчирхийлэл-1, Бие махбодын хүчирхийлэл-2, Бэлгийн хүчирхийлэл-3, Сэтгэл зүйн хүчирхийлэл-4, Эдийн засгийн хүчирхийлэл-5	
	16	Хүнд өвчтэй эсэх (тийм-1, үгүй-2)	
	17	Гэр бүлийн гишүүдийн амиа хорлох оролдлого хийж байсан түүх (тийм-1, үгүй-2)	
	18	Архины тогтмол хэрэглээтэй эсэх (тийм-1, үгүй-2)	
	19	Мансууруулах бодисын хамааралтай эсэх (тийм-1, үгүй-2)	
	20	Сэтгэлийн эмгэгтэй бол ӨУА-ын дагуу оношийг кодлох	
	21	Үндсэн оношийн код /S00 0-T88 9/	
	22	Өвчний оношийн код /A00 0-R99 9/	
	23	Гадны шалтгааны код /X60-Y98/	
	24	Амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдал /Z55-Z65, Z80-Z99/	
	25	Амиа хорлох оролдлого хийхдээ архи хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	
	26	Амиа хорлох оролдлого хийхдээ мансууруулах бодис хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	
	27	Өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	
	28	Урьд нь амиа хорлох оролдлого хийсэн удаа	
	29	Гэрээслэл үздээсэн эсэх (тийм-1, үгүй-2)	
	30	Эмнэлгийн тусламж авсан эсэх (тийм-1, үгүй-2)	
	31	Эмнэлгийн ямар тусламж авсан тухай тэмдэглэх	
	32	Сэтгэл зүйн зөвлөгөө авсан эсэх (тийм-1, үгүй-2)	
	33	Шилжүүлсэн газар 1. Гэрлүүтээ, 2. Сэтгэлийн тасаг руу, 3. Бусад тасагуу, 4. Нас барсан, 5. Бусад	



Эрүүл мэндээс БУСАД байгууллагад хөтлөгдөх маяг

АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО ХИЙСЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

А	1	Эцэг /эх/-ийн нэр, Өөрийн нэр Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар	Он сар өдөр	
			2	3
		Амиа хорлох оролдлого хийсэн		
		Цаг, минут		
		Долоо хоногийн гаригийн нэрийг бичих		
		Амиа хорлох үйлдэл хийсэн газар		
		Нас		
		Хүйс		
		Боловсрол /код/		
		Мэргэжил		
		Хөдөлмөр эрхлэлтийн байдал /код/		
		Хөдөлмөр эрхлэхгүй шалтгаан /код/		
		Г эрээслэлийн байдал /код/		
		Тогтмол хаяг		
		13		
		Хүчирхийлэлд өртсөн эсэх (тийм-1, үгүй-2)		
		Хүчирхийллийн хэлбэр Үд хайхрах хүчирхийлэл-1, Бие махбодын хүчирхийлэл-2, Бэлгийн хүчирхийлэл-3, Сэтгэл зүйн хүчирхийлэл-4, Эдийн засгийн хүчирхийлэл-5		
		Хүнд өвчтэй эсэх (тийм-1, үгүй-2)		
		Г эр бүлийн гишүүдийн амиа хорлох оролдлого хийж байсан түүх (тийм-1, үгүй-2)		
		Архины тогтмол хэрэглээтэй эсэх (тийм-1, үгүй-2)		
		Мансууруулах бодисын хамааралтай эсэх (тийм-1, үгүй-2)		
		Амиа хорлох оролдлого хийхдээ хэрэглэсэн арга		
		Амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдал		
		Амиа хорлох оролдлого хийхдээ архи хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)		
		Амиа хорлох оролдлого хийхдээ мансууруулах бодис хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)		
		Өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан эсэх (тийм-1, үгүй-2)		
		Урьд нь амиа хорлох оролдлого хийсэн удаа		
		Г эрээслэл үлдээсэн эсэх (тийм-1, үгүй-2)		
		Эмнэлгийн тусламж авсан эсэх (тийм-1, үгүй-2)		
		Эмнэлгийн ямар тусламж авсан тухай тэмдэглэх		
		Сэтгэл зүйн зөвлөгөө авсан эсэх (тийм-1, үгүй-2)		
		Шилжүүлсэн газар 1. Гэрлүүгээ, 2. Сэтгэлийн тасаг руу, 3. Бусад тасагруу, 4. Нас барсан, 5. Бусад		
		29		
		30		



Бүх шатны боловсролын байгууллагад хөтлөгдөх маягт

АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО ХИЙСЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

Д/д	Эцэг /Эх/-ийн, Нэр Регистрийн дугаар	Нас, Хүйс	Боловсрол	Ажил, мэргэжил	Гэрлэлтийн байдал	Гэр бүлийн хүчирхийлэлд байсан эсэх	Удамд нь амиа хорлосон болон амиа хорлох оролдлого хийсэн хүн байсан эсэх	Удамд сэтгэцийн эмгэгтэй хүн байдаг эсэх	Амиа хорлох оролдлого хийх шалтгаан	Үйлдэл хийсэн			Амиа хорлох оролдлого хийхдээ хэрэглэсэн арга бичих	Амиа хорлох оролдлого хийхдээ эм хэрэглэсэн бол эмийн нэр, тоог бичих)	Эмнэлгийн ямар тусламж авсан болох	Эмчилгээний зардал төгрөгөөр	Сэтгэл зүйн зөвлөгөө авахыг зөвлөсөн эсэх
										Он, сар, өдөр	Цаг, минут	Газар					
А		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16



ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын ОНЫ
..... сарын өдрийн...дугаар
тушаалын гурав дугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагад хөтлөгдөх маяг

АМИА ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ МАЯГТ

А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	
Д/д	Эцэг /эх/-ийн нэр, Өөрийн нэр Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар	Амиа хорлосон Он сар өдөр	Цаг, минут	Долоо хоногийн гаригийн нэрийг бичих	Амиа хорлох үйлдэл хийсэн/нас барсан газар	Нас	Хүйс	Боловсрол /код/	Мэргэжил	Хөдөлмөр эрхлэлтийн байдал /код/	Гэрлэлтийн байдал /код/	Тогтмол хаяг	Хүчирхийлэлд өртсөн эсэх (тийм-1, үгүй-2)	Хүчирхийллийн хэлбэр Үл хайхрах хүчирхийлэл-1, Бие махбодын хүчирхийлэл-2, Бэлгийн хүчирхийлэл-3, Сэтгэл зүйн хүчирхийлэл-4, Эдийн засгийн хүчирхийлэл-5	Хүнд өвчтэй эсэх (тийм-1, үгүй-2)	Гэр бүлийн гишүүдийн амиа хорлох оролдлого хийж байсан түүх (тийм-1, үгүй-2)	Архины тогтмол хэрэглээтэй эсэх (тийм-1, үгүй-2)	Мансууруулах бодисын хамааралтай эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэцийн эмгэгтэй бол ӨУХА-ын дагуу оношийг кодлох	Үндсэн оношийн код /S00.0-T88.9/	Өвчний оношийн код /A00.0-R99.9/	Гадын шалтгааны код /X60-Y98/	Амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдал /Z55-Z65, Z80-Z99/	Амиа хорлох үедээ архи хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	Амиа хорлох үедээ мансууруулах бодис хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	Өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	Урьд нь амиа хорлох оролдлого хийсэн удаа	Гэрээстэй үлдээсэн эсэх (тийм-1, үгүй-2)	

ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын ОНЫ
..... сарын өдрийн...дугаар
тушаалын гурав дугаар хавсралт

Эрүүл мэндээс БУСАД байгууллагад хөтлөгдөх маяг

АМИА ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

Д/д	Эцэг /эх/-ийн нэр, Өөрийн нэр Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар	Амиа хорлос он Он сар өдөр	Цаг, минут	Долоо хоногийн гаригийн нэрийг бичих	Амиа хорлох үйлдэл хийсэн/нас барсан газар	Нас	Хүйс	Боловсрол /код/	Мэргэжил	Хөдөлмөр эрхлэлтийн байдал /код/	Гэрээлтийн байдал /код/	Тогтмол хаяг	Хүчирхийлэлд өртсөн эсэх (тийм-1, үгүй-2)	Хүчирхийллийн хэлбэр Үл хайхрах хүчирхийлэл-1, Биө махбоцон хүчирхийлэл-2, Болгийн хүчирхийлэл-3, Сэтгэл зүйн хүчирхийлэл-4, Эдийн заагийн хүчирхийлэл-5	Хүнд өвчтэй эсэх (тийм-1, үгүй-2)	Гэр бүлийн гишүүдийн амина хорлох ороолдого хийж байсан түүх (тийм-1, үгүй-2)	Архивны тогтмол хэрэглээтэй эсэх (тийм- 1, үгүй-2)	Мансууруулах бодисын хамааралтай эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэцийн эмгэгтэй бол ӨОУА-ын дагуу оношийг кодлох	Амиа хорлоход хэрэглэсэн арга	Амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдал	Шалтгаан	Амиа хорлох үедээ архи хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	Амиа хорлох үедээ мансууруулах бодис хэрэглэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	Өмнө нь амина хорлох ороолдого хийж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	Урьд нь амина хорлох ороолдого хийсэн удаа	Гэрээлэл үйлдэсэн эсэх (тийм-1, үгүй-2)	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	



ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын оны
..... сарын өдрийн...дугаар тушаалын
гурав дугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагад хөтлөгдөх маяг

АРХИНД ДОНТОХ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

Д/д	Эцэг /эх/-ийн нэр, Нэр Регистрийн дугаар	Тогтмол хаяг	Мэргэжил Боловсрол	Ажлын газрын хаяг, албан тушаал	Нас, Хүйс	Гэр бүлийн байдал (сэргэсэн-1, салсан-2, бэлбэсэн-3, ганц бие-4)	Сэтгэцийн эмгэгийг улмаас эмчийн хяналтад байдаг эсэх (тийм-1, үгүй-2)	Шүүх сэтгэгц эмгэг судлалын шинжилгээнд орж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	Шүүх сэтгэгц эмгэг судлалын шинжилгээнд орсон удаа		Үндсэн онош /ӨОУА-10/ F10.2-F10.9	Албадан эмчлэгэнд хамрагдаж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	Архи хэрэглэсэн хугацаа	Архины хор хөнөөлийн талаарх сургалтад хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Дуршил бууруулах эмийн эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Харшил үүсгэх (бух, тарих, суулгац) эмийн эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэл зүйн (кор) эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэгц нийгмийн сэргээн засах эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Өөртөө туслалх бүлгийн эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Эцэг, эх архины хамааралтай эсэх (тийм-1, үгүй-2)	
									Анх	Дагтан												
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	



ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын оны
..... сарын өдрийн...дугаар
тушаалын гурав дугаар хавсралт

Эрүүл мэндээс БУСАД байгууллагад хөтлөгдөх маяг

АРХИНД ДОНТОХ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

Д/д	Эцэг /эх/-ийн нэр, Нэр Регистрийн дугаар	Тогтмол хаяг	Мэргэжил	Боловсрол	Ажил эрхлэлт (1. Ажилгүй, 2. Ажилтай, 3. Гэрлэлд, 4. Оюутан, 5. Сурагч, 6. Бусад)	Ажлын газрын хаяг, албан тушаал	Нас, Хүйс	Гэр бүлийн байдал (гэрлэсэн-1, салсан-2, бэлбэсэн-3, ганц бие-4)	Цэргийн алба хаасан эсэх (тийм-1, үгүй-2)	Эцэг, эх архины хамааралтай эсэх (тийм-1, үгүй-2) Сэтгэцийн эмгэгийн улмаас эмчийн хяналтад байдаг эсэх (тийм-1, үгүй-2)	Гэмт хэрэгт холбогдсо н эсэх		Шүүх сэтгэг эмгэг судлалын шинжилгээнд орж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	Үндсэн онош /ӨСМА-10/ F10.2-F10.9	Албадан эмчилгээнд хамрагдаж байсан эсэх (тийм- 1, үгүй-2)	Алх хэргэн насанд хэрэглэж эхэлсэн эсэх	Архи хэрэглэсэн зугацаа	Эрүүлжүүлэхэд орж байсан эсэх (тийм-1, үгүй-2)	Эрүүлжүүлэхэд орж байсан тоо бичих	Архины хор хөнөөлийн таларх сургалтад хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Дуриил бууруулах эмийн эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Харшил үүсгэх (уух, тарих, суулгац) эмийн эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэл зүйн (код) эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)	Сэтгэг нийгмийн сэргээн засах эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2) (АА цуглаанд хамрагдсан)	Өөртөө туолах бүлгийн эмчилгээнд хамрагдсан эсэх (тийм-1, үгүй-2)		
											Алх	Давтан																
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	



ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын
..... оны..... сарын өдрийн...дугаар
тушаалын гурав дугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагад хөтлөгдөх маяг

МАНСУУРУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

Д/д	Эцэг /эх/-ийн нэр, Нэр Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар	Тогтмол хаяг	Мэргэжил	Боловсрол	Ажлын газрын хаяг, албан тушаал	Нас, Хүйс	Гэр бүлийн байдал (гэрлэсэн-1, сагаан-2, болбосон-3, ганц бие-4)	Сэтгэцийн эмчийн хяналтад байдаг эсэх (тийм, үгүй)	Гэмт хэрэгт холбогдсон эсэх (тийм-1, үгүй-2)	Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээнд орсон удаа		Үндсэн онош /ӨСХА-10/ F11-F16, F18, F19	Одоо хэрэглэж буй мансууруулах бодисын нэр	Хэрэглэсэн хугацаа	Нэг удаагийн хэрэглэх тун, хэмжээ	Хоногт хэрэглэх давтамж	Мансууруулах бодисын хор хөнөөлийн талаарх сургалтад хамрагдсан эсэх (тийм, үгүй)	Эмийн эмчилгээнд хамрагдсан эсэх		Сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсан эсэх		Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээнд хамрагдсан эсэх	Опниодын орлуулах эмчилгээ хийлгэсэн эсэх (тийм, үгүй)		
										Анх	Давган							Амбулаторит	Стационарт	Амбулаторит	Стационарт				
A	1	2	3	4	5	6	7	8	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22		



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЭМС/ХЗДХС/ ХНХС/БШУС-ын оны
..... сарын өдрийн...дугаар тушаалын гурав
дугаар хавсралт

Эрүүл мэндээс БУСАД байгууллагад хөтлөгдөх маяг

МАНСУУРУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

А	Д/д	Эцэг /эх/-ийн нэр, Нэр Регистрийн дугаар/Бүртгэлийн дугаар	Тогтмол хааг	Мэргэжил	Боловсрол	Ажил эрхлэлт (1. Ажилгүй, 2. Ажилтай, 3. Группэй, 4. Оюутан, 5. Сурагч, 6. Бусад)	Ажлын газрын хааг, албан тушаал	Нас, Хүйс	Гэр бүлийн байдал (гэргэсэн-1, салсан-2, бэлбэсэн-3, ганц бие-4)	Цэргийн алба хавсан эсэх (тгйм-1, үгүй-2) Сэтгэцийн эмчийн хяналтад байдаг эсэх (тгйм, тгүй)	Гэмт хэрэгт холбогдс он эсэх	Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээ энд орсон удаа	Үндсэн онош /ӨСҮА-10/F11-F16, F18, F19	Одоо хэрэглэж буй мансууруулах бодисын нэр	Анх хүдэн насанд хэрэглэж эхэлсэн эсэх /бичих/	Хэрэглэсэн хугацаа	Нэг удаагийн хэрэглэх тун, хэмжээ	Хонгог хэрэглэх давтамж	Мансууруулах бодисын хор хөнөөлийн талаарх сургалтад хамрагдсан эсэх (тгйм, үгүй)	Эмийн эмчилгээ нд хамрагдсан эсэх	Сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсан эсэх	Сэтгэл нийгмийн сэргээн засах эмчилгээнд хамрагдсан эсэх (NA дулаанд хамрагдсан)	Огноодын орлуулах эмчилгээ хийгээсэн эсэх (тгйм, үгүй)	Албадан эмчилгээн д хамрагдсан	Архи хэтрүүлж хэргэлзлэг эсэх (тгйм-1, үгүй-1)					
																										Анх	Давган	Анх	Давган	Анх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЭМС/ХЭДХС/ ХНХС/БШУС-ын
..... оны..... сарын өдрийн...дугаар
тушаалын гурав дугаар хавсралт

Бүх шатны боловсролын байгууллагад хөтлөгдөх маягт

АРХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭТЭЙ ХҮҮХЭД ЗАЛУУСЫ МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

Байгууллагын нэр.....

№	Сар, өдөр	Эцэг/эх/-ийн нэр, Нэр Регистрийн дугаар	Нас	Хүйс	Тогтмол хаяг	Боловсрол	Сургуулийн нэр, анги, курс	Хэрэглээ		Үндсэн онош /Сэтгэцийн эмгэг ӨОУА-10/ Ба хэрэглэсэн бодисын нэр	Зөвлөгөө өгсөн, нарийн мэргэжлийн эмчид явуулсан хүний тоо	Сэтгэл засал эмчилгээнд хамруулсан хүний тоо	Шинээр хяналтанд авсан хүний тоо	Хэрэглэж буй бодисын нэр	Хөгжлийн бэрхшээлтэй эсэх тийм (+), үгүй (-) ХЧД-ын хувь
								Шинэ	Хуучин						
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15



ХАВСРАЛТ 3
ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ

..... оны сарын өдөр Дугаар/...../..... Улаанбаатар хот

Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.14, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.3 дах заалтууд, Монгол улсын ерөнхийлөгчийн 2019 оны 05 сарын 30 өдрийн 104 дүгээр дугаартай зарлигийн 12 ба 13 дугаарт зүйл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” тунхагласан зорилгын 3.5.1, 3.4.2 дугаар заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журмыг нэгдүгээр, нэр томъёоны тодорхойлолт, тайлбарыг хоёрдугаар, эрүүл мэндийн бус салбарын сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын маягт болон бүртгэх зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн яам “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийг бүртгэх **тандалтын тогтолцоог** нэгсэн санг байгуулж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Тандалт судалгаа, статистикийн алба”-нд уг мэдээллийг цуглуулах, дамжуулах, нэгтгэх, эргэн мэдээлэх, дүн шинжилгээ хийх ажлыг үндэсний түвшинд зохион байгуулж, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (В.Баярмаа)-д даалгасугай.

3. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн тусламж үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудад “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан, архи болон мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн тохиолдлын тоог” бүртгэж, 4 яамны хамтарсан мэдээллийн нэгсэн санд сар тутам оруулж сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мэдээлж байхыг үүрэг өгч, хянаж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

4. Хууль зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагууд нь өөрийн харьяа байгууллагуудад “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан, архи болон мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн тохиолдлын тоог” бүртгэж, 4 яамны хамтарсан



мэдээллийн нэгсэн санд сар тутам оруулж сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мэдээлж байхыг үүрэг өгч, хянаж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

5. **Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэст** Монгол улсын хэмжээнд:

Нэг дүгээрт: Амиа хорлох оролдлого хийсэн, амиа хорлож нас барсан тохиолдлын тоо ба шалтгаан нөлөөлөх хүчин зүйлс гэх мэт мэдээллүүдийг

Хоёр дугаарт: Архи болон мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн

- a. шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоог,
- b. Албадан эмчилгээнд хамрагдсан тохиолдлын тоог
- c. Гэмт хэрэгт холбогдсон тохиолдлын тоо
- d. АА цуглаанд хамралдсан тохиолдлын тоо зэрэг мэдээллүүдийг дэлгэнгүй бүртгэж бүртгэж, 4 яамны хамтарсан мэдээллийн нэгсэн санд сар тутам оруулж сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мэдээлж байхыг тус тус үүрэг болгосугай.

6. **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам** Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 107 гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага, мэдээлэл хүлээн авах утас гэх мэт төрийн болон төрийн бус бүх байгууллагуудад “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан, архи болон мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн тохиолдлын тоог” бүртгэж, 4 яамны хамтарсан мэдээллийн нэгсэн санд сар тутам оруулж сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мэдээлж байхыг үүрэг өгч, хянаж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

7. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг харьяа яамнуудын зохих мэргэжилдэнгүүт болон Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Эрүүлжүүлэх газар, Цагдаагийн байгууллага, Шүүхийн эмнэлгийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хэлтсийн дарга, захирал, бүх шатны шүүх цагдаа, боловсролын байгууллагын дарга нарт даалгасугай.

8. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол шинжлэх ухааны яамнуудын төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус даалгасугай.



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
С.ЧИНЗОРИГ	Б.ЭНХБАЯР	Х.БУЛГАНТУЯА	Л.ЭНХ-АМГАЛАН

ЭМС/ХЗДХС/ХНХС/БШУС-ын оны
..... сарын өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

“Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн тулгамдсан асуудлын бүртгэх тандалтын тогтолцооны ажиллах журам

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын тогтолцоо /цаашид бүртгэл тандалтын тогтолцоо гэнэ/ гэдэг нь үндэсний хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчтой холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулах, бүртгэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөхөд мэдээллээр хангах нотолгоонд суурилсан хариу арга хэмжээ авах цогц үйл ажиллагааг хэлнэ.
- 1.2 Бүртгэл тандалтыг хүн амд суурилсан (амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчтой холбоотой **тулгамдсан асуудлын** мэдээ, мэдээллийг бүртгэдэг байгууллагуудын мэдээлэлд тулгуурласан) хэлбэрээр зохион байгуулна.
- 1.3 Бүртгэл тандалтаар Монгол улсын нийт хүн амын дундах амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчтой холбоотой бүх мэдээллийг цуглуулж бүртгэнэ. Гадаадын харьяат иргэдийн амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчтой холбоотой мэдээ, мэдээллийг тусгай маягтаар бүртгэнэ.
- 1.4 Бүртгэл тандалтын тогтолцоо нь амиа хорлосон тохиолдол бүрийг, амиа хорлох оролдлого хийсэн анхан, давтан тохиолдлуудыг амиа хорлох, амиа хорлох оролдлого хийхэд хүргэсэн шалтгаан харгалзахгүй бүртгэх, архи болон мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн анх шинээр болон давтан бүртгэгдсэн тохиолдлын тоо, албадан эмчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо, гэмт хэрэгт холбогдсон тохиолдлын тоо, АА цуглаанд хамралдсан тохиолдлын тоо зэрэг мэдээллүүдийг дэлгэнгүй бүртгэж цуглуулна.
- 1.5 Бүртгэл тандалтын мэдээнд амиа хорлосон тохиолдол, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлуудыг амиа хорлосон аргыг харгалзахгүйгээр мэдээлэл цуглуулж бүртгэх ба амиа хорлох тухай бодол санаагаа бусдад илэрхийлсэн бол холбогдох найз нөхөд, гэр бүлийн гишүүд, байгууллагад хандсан мэдээллийн дагуу (эмч, цагдаагийн байгууллага, сургуулийн захиргаа, багш гэх мэт) нотолгоонд суурилсан мэдээллийг багтаана.

1.6 Бүртгэл тандалтын мэдээллийг бүртгэхдээ Өвчний олон улсын Х ангиллын гарын авлагын F00-F99 кодоор сэтгэцийн ба зан төрхийн эмгэг, R40-46, Z00-99, Y90, Y91 кодоор сэтгэцийн бусад тулгамдсан асуудал, эмнэлэгт хандах болсон шалтгаан болон Х60 - Х84 кодоор “Зориуд санаатайгаар өөрийгөө хорлох” гэсэн хэсгийг, хэрэв амиа хорлосон болон амиа хорлох оролдлого хийгч нь сэтгэцийн эмгэгийн улмаас үйлдлийг хийсэн бол Өвчний олон улсын 10 дугаар ангиллын гарын авлагын F бүлгийн оношийн кодыг, Архи болон мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг Өвчний олон улсын 10 дугаар ангиллын гарын авлагын F бүлгийн оношийн F10-F19 кодыг тус тус ашиглана.

1.7 Бүртгэл тандалтын тогтолцоо нь мэдээллийг бүртгэхдээ тусгай маягтын асуулт тус бүрээр нэг бүрчлэн бүртгэнэ

1.8 Дараах эрүүл мэндийн болон бусад байгууллагууд нь бүртгэл тандалтын тогтолцооны мэдээний эх сурвалж байгууллагууд болно. Үүнд:

Эрүүл мэндийн байгууллагууд: Заавал мэдээлэл өгөх байгууллагууд:

- ✓ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв
- ✓ Сум дундын эмнэлэг
- ✓ Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг
- ✓ Аймаг, дүүргийн сэтгэцийн тасаг, кабинетууд
- ✓ Нийслэлийн түргэн тусламжийн төв
- ✓ Гэмтэл согог судлалын үндэсний төв
- ✓ Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
- ✓ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)
- ✓ Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- ✓ Аддиктологийн төв
- ✓ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

Шаардлагатай буюу хүчирхийлэлд өртсөн, амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд мэдээлэл өгөх эрүүл мэндийн байгууллагууд:

- Дээр заагдсанаас бусад эрүүл мэндийн бүх шатны төрийн ба хувийн байгууллагууд, үндэсний төвүүд

Эрүүл мэндийн бус байгууллагууд:

- Монгол улсын ерөнхий прокурорын газар
- Цагдаагийн ерөнхий газар
- Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэст
- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх хэлтэст
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн - Шүүх эмнэлгийн шинжилгээний газар
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв,
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв,
- Бүх шатны боловсролын байгууллагууд

1.9 Бүртгэл тандалтын тогтолцооны мэдээний нэгдсэн санд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний хяналтын мэдээ, сэтгэл засал эмчилгээний мэдээ, шүүх сэтгэц эмгэг судлалын дүгнэлт шинжилгээ, сэтгэцийн эмгэгийн шалтгаант нас баралт, сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан өвчтөний мэдээ, сэтгэцийн тулгамдсан асуудалтай холбоотой мэдээний сан тус тус багтана.

- 1.10 Бүртгэл тандалтын тогтолцоонд сэтгэцийн эмгэгийн тохиолдлын түвшин, шинээр бүртгэгдсэн сэтгэцийн өвчлөлийн түвшин, амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшин, шинээр оношлогдсон өвчтөнг идэвхитэй хяналтанд авсан хувь, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүсийн сайжралын хувь, сэтгэц нөлөөт үнэгүй эм авдаг өвчтөний эзлэх хувь, сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан өвчтний хувь, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн эмчилгээний хамралт зэрэг үндсэн үзүүлэлтийг тооцож оруулна.
- 1.11 Бүртгэл тандалтын тогтолцоонд эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн программ хангамжийг ашиглана.
- 1.12 Бүртгэл тандалтын мэдээллийг цуглуулахдаа үйлчлүүлэгчийн холбогдох мэдээлэл, регистрийн дугаараар бүртгэж, хянан тогтоож, мэдээллийн давхардлыг арилгана.
- 1.13 Бүртгэл тандалтын тогтолцооны цуглуулсан мэдээ нь Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд болон бусад холбогдох заавар журмын дагуу хамгаалагдана.
- 1.9. Төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагууд, холбогдох эмнэлгийн бус байгууллагууд нь тандалт тогтолцоотой холбогдох хууль, тогтоомж, тушаал, журам, стандартыг дагаж мөрдөнө.
- 1.10. Бүртгэл тандалтын тогтолцоо нь нийтийг хамарсан халдварт өвчний үед СЭМҮТ-ийн ерөнхий захирлын тушаалаар зохион байгуулагдан ажиллаж буй хариу арга хэмжээний багийг удирдан зохион байгуулах, тандалт мэдээллийг цуглуулах, мэргэжил арга зүйлгээр ханган ажиллана.

Хоёр. Мэдээний төрөл

- 2.1 Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлуудын тохиолдлын мэдээллийг дараах төрлүүдээр цуглуулна.
- Өрхийн эмчийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн бүртгэл – ӨЭ-10
 - Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хяналтын бүртгэл - СЭ-1
 - Шүүх сэтгэц эмгэг судлалын дүгнэлт шинжилгээний бүртгэл – СЭ-3
 - Амиа хорлосон болон амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийн бүртгэл СЭ4
 - Албадан эмчлүүлсэн, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй хүмүүсийн бүртгэл – СЭ-5
 - Мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн бүртгэл – СЭ-6
 - Амиа хорлосон тохиолдол бүрд улсын ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага “Амиа хорлох тохиолдлыг бүртгэх маяг”-ыг бөглөн ЭМХТСтатистик, мэдээлэл технологийн албанд сар тутам цаасан хэлбэрээр мэдээлнэ.
 - Эрүүл мэндийн байгууллагууд нь амбулатори болон стационарын бүртгэлийн дор дурдсан мэдээний сан ба маягыг ашиглана.
 - ✓ Өвчний түүх СТ-1
 - ✓ Эмчийн үзлэгийн бүртгэл – 1А , 1Б
 - ✓ Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний бүртгэл ШЭ-2, ШЭ-3, ШЭ-9
 - ✓ Амиа хорлох оролдлого хийсэн хүний тоо ЭМТ - 305.5.1, амиа хорлож нас барсан хүний тоо ЭМТ-305.5.2, амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийн

мэдээ, амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдлаар ЭМТ305.5.3, амиа хорлож нас барсан хүмүүсийн мэдээ, амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдлаар ЭМТ-305.5.4, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол, оношоор ЭМТ-305.5.5, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын гадны шалтгаан үр дагавар ЭМТ-305.5.6, амиа хорлож нас барсан тохиолдлын гадны шалтгаан үр дагавар ЭМТ-305.5.7,

- ✓ Цагдаагийн болон бусад байгууллагуудаас авах бүртгэлийн маягт. Үүнд: цагдаа, прокурор, шүүх эмнэлэг, боловсрол, хөдөлмөр нийгэм хамгаалал /уг журмаар бүртгэлийн маягтыг батлуулна/

- 2.1 Амиа хорлосон тохиолдол бүрийг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ” АМ-7 маягтаар бүртгэн мэдээлнэ.
- 2.2 Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв болон тусгай мэргэжлийн төвүүд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас осол гэмтлийн бүртгэгдсэн мэдээг сар бүрийн 5-ны дотор Н-info программд шивж оруулан цахим хэлбэрээр хүлээж авна.
- 2.3 Амиа хорлосон тохиолдлын бүртгэлийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээний албанд мэдээлнэ.

Гурав. Мэдээний эх сурвалж байгууллагын үүрэг, мэдээний урсгал

3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үүрэг

- Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч нь харъяа нутаг дэвсгэрийнхээ хүн амаас амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудалтай тохиолдол тус бүрийг тусгай журналд холбогдох СЭ-1, СЭ4, СЭ-6, ӨЭ-10 маягтуудын дагуу бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр сар бүр мэдээлнэ.
- Нийгэм сэтгэлзүйн тусламж үйлчилгээнд хамрагдсан амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудалтай тохиолдол болон амиа хорлохоор оролдогсад болон амиа хорлосон тохиолдлын гэр бүл, ойр дотны хүний тоон мэдээг бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр улирал бүрийн сүүлийн өдөр мэдээлнэ.
- Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлаа тогтоож шийдвэрлэх зорилгоор холбогдох эмч сувилагч, статистикчдын уулзалтыг өрх сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг жил бүрийн 10 дугаар сард зохион байгуулна.



3.2. Аймаг, дүүрэг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, НЭМТ, Эрүүл мэндийн газрын үүрэг

- Аймаг, дүүрэг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмч нь харъяа нутаг дэвсгэрийнхээ хүн амаас амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудалтай тохиолдол тус бүрийг тусгай журналд холбогдох СЭ-1, СЭ3, СЭ-4, СЭ-5, СЭ-6 маягуудын дагуу бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр сар бүр мэдээлнэ.
- Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудал болон амиа хорлох үзэгдлийн (амиа хорлож нас барах болон амиа хорлохыг оролдох) шинэ тохиолдлыг бүртгэсэн Нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмч (гэмтлийн, яаралтай тусламжийн, сэтгэцийн, шүүхийн шинжээч гэх мэт) нар амиа хорлохыг оролдсон болон амиа хорлож нас барсан тохиолдлыг мэдээлэх хуудас маягтыг хөтлөн, тусгай журналд бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр тухай бүрд нь мэдээлнэ.
- Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэн нь сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудал болон амиа хорлох үзэгдлийн бүртгэл тандалтын мэдээний давхардлыг шалган нэгтгэж, мэдээний сан үүсгэн статистикч эмч харъяалах удирдлагаар хянуулж баталгаажуулна.
- Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн статистикч эмч нь энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтын хүснэгт 1, 2-д заасан үзүүлэлтүүдийн дагуу аймаг, дүүргийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтний нэгтгэсэн мэдээ, мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт тавьж баталгаажуулан улирал бүрийн мэдээг дараа улирлын эхний сарын 10-нд багтаан цаасан болон цахим хэлбэрээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд илгээнэ.
- Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн статистикч эмч нь Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтний сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний бүртгэл тандалтын мэдээний хагас, бүтэн жилийн нэгтгэл, тайланд энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтын хүснэгт 1, 2-д заасан үзүүлэлтүүдийн дагуу хяналт тавьж, харъяалах удирдлагаар баталгаажуулан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, ЭМХТ-д мэдээлнэ.
- Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэн нь сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын хяналтын бүртгэлээс алдагдсан, шилжилт хөдөлгөөн тодорхойгүй хүний мэдээллийг өөрийн аймаг, дүүргийн иргэний бүртгэлийн хэлтсийн мэдээний санд байгаа мэдээлэлтэй тулгалт хийн тодруулж, жилийн эцэст СЭМҮТ болон ЭМХТ-д илгээнэ.
- Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар сэтгэцийн эмгэг, Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын чанар, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, бүртгэл тандалтын уялдаа, давхардлыг арилгах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, амиа хорлох үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хянах, тандах үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах зорилгоор оролцогч бүх

байгууллагуудын эмч, мэргэжилтний нэгдсэн уулзалтыг жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулна.

- Бүртгэл тандалтын тогтолцоог хэрэгжүүлж байгаа харъяалах байгууллагуудын үйл ажиллагаанд жил бүр дэмжлэгт хяналт зохион байгуулж удирдлага, аргазүйн зөвлөмжөөр ханган, байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ.
- Үндэсний хэмжээнд шийдвэрлэх асуудлын талаар ЭМХТ нь Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Эрүүл Мэндийн Яам, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол Шинжлэх Ухааны Яаманд жил бүр мэдээлнэ.

3.3. Төв болон тусгай мэргэжлийн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үүрэг

- Төв болон тусгай мэргэжлийн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч нь сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудалтай тохиолдлыг илрүүлэн тусгай журналд холбогдох СЭ1, СЭ-3, СЭ-4, СЭ-5, СЭ-6 маягтуудын дагуу тус тус бүртгэн статистикч их эмчид мэдээг тухай бүр нь мэдээлнэ.
- Статистикч их эмч нь эрүүл мэндийн байгууллагын сэтгэцийн эмгэг, Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудал болон амиа хорлох үзэгдлийг батлагдсан маягтын дагуу программд оруулж, СЭМҮТ, ЭМХТ-д дараа улирлын эхний сарын 10-нд цаасан болон цахим хэлбэрээр мэдээлнэ.

3.4. Монгол улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, ШШҮХийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын үүрэг

- Тухайн газарт задлан шинжилгээнд хамрагдан амиа хорлож нас барсан байж болох тохиолдол бүрийг бүртгэн мэдээлэх зохих маягтын дагуу бүртгэн ЭМХТ-д дараа улирлын эхний сарын 10-нд мэдээлнэ.

3.5. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг

- Аймаг, дүүрэг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, НЭМТ, Эрүүл мэндийн газар, төв тусгай мэргэжлийн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, шүүх эмнэлгийн шинжилгээний газар зэрэг амиа хорлох үзэгдлийн бүртгэл мэдээлэлтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагуудаас илгээсэн амиа хорлох үзэгдлийн бүртгэл-мэдээллийн тогтолцооны эрүүл мэндийн салбарын мэдээг мэдээний урсгалын дагуу хүлээн авч, нэгтгэн давхардлыг арилган хянаад зохих журмын дагуу мэдээлнэ.
- Тус төвийн статистик мэдээллийн албаны мэдээллийн санд нэгтгэгдсэн амиа хорлох үзэгдлийн бүртгэл-мэдээллийн нэгдсэн мэдээллийн тайлан мэдээг дараа улирлын эхний сарын 15-нд цаасан болон цахим хэлбэрээр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Эрүүл Мэндийн Яам, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдээлнэ.

3.6. Бүх шатны боловсролын байгууллагын үүрэг

- Бүх шатны боловсролын байгууллагын эмч, сэтгэлзүйч нь хариуцсан нэгжийнхээ хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглээний тулгамдсан асуудалтай тохиолдол тус бүрийг тусгай журналд энэхүү тушаалын 3 дугаар хавсралтын 4.1 дүгээр бүртгэлийн маягтын дагуу бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн

сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр сар бүр мэдээлнэ.

- Нийгэм сэтгэлзүйн тусламж үйлчилгээнд хамрагдсан сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглээний тулгамдсан асуудалтай тохиолдол болон амиа хорлохоор оролдогсод болон амиа хорлосон тохиолдлын гэр бүл, ойр дотны хүний тоон мэдээг энэхүү тушаалын 3 дугаар хавсралтын 4.2 дугаар хуудасны дагуу бүртгэж, харъяалах удирдлагаар хянаж баталгаажуулан аймаг, дүүргийн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэргэжилтэнд цаасан болон цахим хэлбэрээр улирал бүрийн сүүлийн өдөр мэдээлнэ.
- Сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглээний тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлаа тогтоож шийдвэрлэх зорилгоор холбогдох боловсролын байгууллагын эмч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч нарын уулзалтыг жил бүрийн 10 дугаар сард зохион байгуулна.

3.7. Цагдаагийн байгууллагуудын үүрэг

- Цагдаагийн байгууллагуудад бүртгэгдсэн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй, хүчирхийллийн хохирогч, амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлож нас барсан байж болох тохиолдлын бүртгэл, архи мансууруулах бодисын хэрэглэгч ба донтогчийн мэдээллийг ЦЕГ-ын мэдээлэл, технологийн төв зохих журмын дагуу нэгтгэн, мэдээллийн чанар, давхардлыг арилган хянаж баталгаажуулан дараа улирлын эхний сарын 15-нд цаасан болон цахим хэлбэрээр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Эрүүл Мэндийн Яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд мэдээлнэ.

3.8. Прокурорын байгууллагуудын үүрэг

- Прокурорын байгууллагаар хянагдан “Амиа хорлож нас барсан” хэмээн шийдвэрлэгдсэн тохиолдлын бүртгэл мэдээллийг зохих журмын дагуу нэгтгэн, мэдээллийн чанар, давхардлыг арилган хянаж баталгаажуулан дараа улирлын эхний сарын 15-нд цаасан болон цахим хэлбэрээр Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Эрүүл Мэндийн Яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдээлнэ.

3.9. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Тандалт судалгаа, статистикийн албаны үүрэг

- Эрүүл мэнд, боловсрол, цагдаа, прокурорын байгууллагуудаас сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хэрэглэгч ба донтогчийн тулгамдсан асуудал болон амиа хорлох үзэгдлийн бүртгэл тандалтын тогтолцооны мэдээг мэдээний урсгалын дагуу хүлээн авч, нэгтгэн дүн шинжилгээ хийнэ.
- Бүртгэл тандалтын тогтолцооны мэдээний чанарыг сайжруулахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- Бүртгэл тандалтын тогтолцоонд “Сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хэрэглэгч ба донтогчийн тулгамдсан асуудал болон амиа хорлох үзэгдлийн үндэсний хэмжээний мэдээллийн сан”-г ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хэрэглэгч ба донтогчийн тулгамдсан асуудал болон амиа хорлох үзэгдэлтэй холбоотой ажилладаг эмч мэргэжилтэн,




боловсрол, цагдаа, прокурорын байгууллагын ажилтнуудын давтан сургалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

3.10. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг

- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын тогтолцооны мэдээг мэдээний урсгалын дагуу хүлээн авч, “Эрүүл мэндийн үзүүлэлт” эмхтгэлд оруулна.
- Бүртгэл тандалтын чанарыг сайжруулахад мэргэжил арга зүйгаар хангаж ажиллана.
- Бүртгэл тандалтын тогтолцоонд “Сэтгэцийн эмгэг, , амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын үндэсний хэмжээний мэдээний сан”-г ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Эмч, мэргэжилтнүүдийн давтан сургалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Зураг 1. Сэтгэцийн эмгэг, сэтгэцийн тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын тогтолцооны мэдээний урсгал





Дөрөв. Мэдээний сан

4.1 Сэтгэцийн эмгэг, , амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлыг бүртгэх мэдээний санг эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөгдөх “Өрхийн эмчийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн бүртгэл”, “Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хяналтын бүртгэл” маягтын дагуу бүрдүүлнэ. Эрүүл мэндийн бус байгууллагууд мөн уг тушаалын 3 дугаар хавсралтын 1.1-4.2 дугаар маягтын дагуу мэдээллийг бүрдүүлнэ.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллагын сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын мэдээний сангийн агуулга

Тохиолдлын хэсэг	Архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудалтай бол	Сэтгэцийн эмгэгтэй бол	Тусламж эмчилгээний төрөл
Эцэг эхийн нэр	Шинэ өвчлөлийн тоо	ХЧА тогтоолгосон хүний тоо	Сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан хүний тоо
Өөрийн нэр	Хуучин өвчлөлийн тоо	Хяналтанд орсон огноо	Эмийн эмчилгээнд хамрагдсан хүний тоо
Регистрийн дугаар	Шинээр хяналтанд авсан хүний тоо	ХЧА%	Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд хамрагдсан хүний тоо
Төрсөн он сар өдөр	Зөвлөгөө өгсөн хүний тоо	Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй хүний тоо	Нийгмийн нөхөн сэргээх тусламжинд хамрагдсан хүний тоо
Нас	Нарийн мэргэжлийн эмчид явуулсан хүний тоо	Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо	Опиодын орлуулах эмчилгээнд хамрагдсан хүний тоо
Хүйс	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	Цэргийн насны эрэгтэйчүүдийн тоо	
Мэргэжил	ХЧА% тогтоолгосон хүний тоо	Үнэгүй эм авдаг хүний тоо	
Ажил эрхлэлтийн байдал	Сэтгэц нөлөөт эм олгосон хүний тоо	Байнгын асаргаанд байдаг хүний тоо	
Албан тушаал		Эдгэрсэн хүний тоо	
Боловсрол		Шилжсэн хүний тоо	



Гэрийн хаяг		Шилжиж ирсэн хүний тоо	
Гэрлэлтийн байдал		Нас барсан хүний тоо	
Онош		Шүүх сэтгэц эмгэг судлалын	
		шинжилгээнд орж байсан хүний тоо	

Хүснэгт 2. Эрүүл мэндийн байгууллагын амиа хорлох тохиолдлын мэдээний сангийн агуулга

Тохиолдлын хэсэг	Амиа хорлож нас барсан бол	Амиа хорлох оролдлого хийсэн бол	Тусламж эмчилгээний төрөл
Эцэг эхийн нэр	Цогцос олдсон огноо (он сар өдөр, гараг)	Үйлдэл хийсэн огноо (он сар өдөр, гараг)	Тусламжийн төрөл (А. Эмнэлгийн Б.Цагдаагийн В.Сэтгэлзүйн)
Өөрийн нэр	Цогцос олдсон цаг хугацаа	Үйлдэл хийсэн цаг хугацаа	Хийгдсэн эмчилгээний төрөл
Регистрийн дугаар	Цогцос олдсон газар, орчин	Үйлдэл хийсэн газар, орчин	Сэтгэлзүйн тусламжийн төрөл
Төрсөн он сар өдөр	Амиа хорлосон огноо (он сар өдөр, гараг)	Бүртгэлийн байдал (А.Анхан шатны ЭМийн байгууллагад Б. Хоёрдогч шатны ЭМ-ийн байгууллагад В. Төв тусгай мэргэжлийн ЭМ-ийн байгууллагад Г.Хувийн хэвшлийн ЭМ-ийн байгууллагад Д.Бусад гм)	Эмчилгээ тусламжийн зардал (төгрөгөөр)
Нас	Амиа хорлосон цаг минут	Үйлдэл хийсэн арга (ӨОУ-ын ангилалын кодоор)	



Хүйс	Бүртгэлийн байдал (А.Анхан шатны ЭМ-ийн байгууллагад Б. Хоёрдогч шатны ЭМийн байгууллагад В. Төв тусгай мэргэжлийн ЭМ-ийн байгууллагад Г.Хувийн хэвшлийн ЭМийн байгууллагад Д.Бусад гм)	Гэмтээсэн эрхтэн, гэмтлийн хэлбэр, хүнд хөнгөний зэрэг	
Мэргэжил	Шүүх эмнэлгийн задлан шинжилгээнд орсон байдал	Үйлдэл хийхдээ архи бусад мансууруулах бодис хэрэглэсэн эсэх	
Ажил эрхлэлтийн байдал	Амиа хорлохдоо хэрэглэсэн арга (ӨОУ-ын ангилалын кодоор)	Амиа хорлох оролдлого хийсэн шалтгаан	
Албан тушаал	Гэрээслэлийн байдал, агуулга	Оролдлого хийгч сэтгэцийн эмгэгээр өвчилсөн байдал (оношийн код)	
Боловсрол	Амиа хорлохоор шийдсэнээ хэн нэгэнд хэлж байсан эсэх	Сэтгэцийн эмгэгийн улмаас хяналтанд байсан эсэх	
Гэрийн хаяг	Амиа хорлогч ямар эрхтнээ гэмтээсэн болох	Биеийн суурь хүнд өвчтэй байсан эсэх (өвчний нэрийг бичих)	
Гэрлэлтийн байдал	Амиа хорлогч биеийн суурь хүнд өвчтэй байсан эсэх (өвчний нэрийг бичих)	Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан эсэх	
Амьд эсэх	Амиа хорлохдоо эм хэрэглэсэн эсэх (эмийн нэр, тоог бичих)	Удамд нь амиа хорлосон эсвэл амиа хорлох оролдлого хийж байсан тохиолдол бий эсэх	
	Амиа хорлохдоо архи, бусад мансууруулах бодис хэрэглэсэн эсэх	Удамд нь сэтгэцийн эмгэгтэй хүн байдаг эсэх	
	Амиа хорлосон шалтгаан	Гэрээслэл үлдээсэн эсэх	
	Сэтгэцийн эмгэгийн улмаас хяналтанд байсан эсэх	Тусламж авсан байдал	



Хүснэгт 3. Эрүүл мэндийн бус байгууллагын сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлын мэдээний сангийн агуулга

Тохиолдлын хэсэг	Архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудалтай бол	Сэтгэцийн эмгэгтэй бол	Тусламж эмчилгээний төрөл
Эцэг эхийн нэр	Шинэ өвчлөлийн тоо	ХЧА тогтоолгосон хүний тоо	Сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан хүний тоо
Өөрийн нэр	Хуучин өвчлөлийн тоо	Хяналтанд орсон огноо	Эмийн эмчилгээнд хамрагдсан хүний тоо
Регистрийн дугаар	Шинээр хяналтанд авсан хүний тоо	ХЧА%	Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох
			сургалтанд хамрагдсан хүний тоо
Төрсөн он сар өдөр	Зөвлөгөө өгсөн хүний тоо	Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо	Нийгмийн нөхөн сэргээх тусламжинд хамрагдсан хүний тоо
Нас	Нарийн мэргэжлийн эмчид явуулсан хүний тоо	Цэргийн насны эрэгтэйчүүдийн тоо	
Хүйс		Эдгэрсэн хүний тоо	
Боловсрол		Шилжсэн хүний тоо	
Сургуулийн нэр		Шилжиж ирсэн хүний тоо	
Анги			
Гэрийн хаяг			
Онош			



Хүснэгт 4. Эрүүл мэндийн бус байгууллагын амиа хорлох тохиолдлын мэдээний сангийн агуулга

Тохиолдлын хэсэг	Амиа хорлож нас барсан бол	Амиа хорлох оролдлого хийсэн бол	Тусламж эмчилгээний төрөл
Эцэг эхийн нэр	Цогцос олдсон огноо (он сар өдөр, гараг)	Үйлдэл хийсэн огноо (он сар өдөр, гараг)	Тусламжийн төрөл (А. Эмнэлгийн Б.Цагдаагийн В.Сэтгэлзүйн)
Өөрийн нэр	Цогцос олдсон цаг хугацаа	Үйлдэл хийсэн цаг хугацаа	Тусламжийн зардал (төгрөгөөр)
Регистрийн дугаар	Цогцос олдсон газар, орчин	Үйлдэл хийсэн газар, орчин	
Төрсөн он сар өдөр	Амиа хорлосон огноо (он сар өдөр, гараг)	Бүртгэлийн байдал (А. Эрүүл мэндийн байгууллагад Б.Цагдаагийн байгууллагад)	
Нас	Амиа хорлосон цаг минут	Үйлдэл хийсэн арга	
Хүйс	Бүртгэлийн байдал (А.Эрүүл мэндийн байгууллагад Б.Цагдаагийн байгууллагад)	Үйлдэл хийхдээ архи бусад мансууруулах бодис хэрэглэсэн эсэх	
Мэргэжил	Шүүх эмнэлгийн задлан шинжилгээнд орсон байдал	Амиа хорлох оролдлого хийсэн шалтгаан	
Ажил эрхлэлтийн байдал	Амиа хорлохдоо хэрэглэсэн арга	Сэтгэцийн эмгэгийн улмаас хяналтанд байсан эсэх	
Албан тушаал	Гэрээслэлийн байдал, агуулга	Гэрээслэл үлдээсэн эсэх	



Боловсрол	Амиа хорлохдоо архи, бусад мансууруулах бодис хэрэглэсэн эсэх	Тусламж авсан байдал	
Гэрийн хаяг	Амиа хорлосон шалтгаан		
Гэрлэлтийн байдал	Сэтгэцийн эмгэгийн улмаас хяналтанд байсан эсэх		
Амьд эсэх			

Тав. Сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын тайлан ба үзүүлэлт

Хүснэгт 5. Бүртгэл тандалтын тогтолцооны тайлан

Тайлангийн төрөл	Тооцох үзүүлэлт
Сэтгэцийн эмгэгийн амбулатор хяналтын тайлан ЭМТ-305.1.1	<ol style="list-style-type: none"> Амбулаторит бүртгэгдсэн сэтгэцийн эмгэгийн нийт өвчлөлийн тоог 10000 хүн амд Сэтгэцийн эмгэгийн шинэ өвчлөлийн тохиолдлын тоог 10000 хүн амд Сэтгэцийн эмгэгийн шинэ өвчлөлийн тохиолдлын нас, хүйс, тоо, хувиар Шинээр оношлогдсон өвчтөнг идэвхтэй хяналтанд авсан тоо, хувиар
Донтох эмгэгийн кабинетийнүйл ажиллагааны тайлан ЭМТ-305.2	<ol style="list-style-type: none"> Донтох эмгэгийн нийт өвчлөлийн тоог 10 000 хүн амд Донтох эмгэгийн шинэ өвчлөлийн тохиолдлын тоог 10 000 хүн амд Донтох эмгэгийн шинэ өвчлөлийн
	<p>тохиолдлын нас, хүйс, тоо, хувиар</p> <ol style="list-style-type: none"> Шинээр оношлогдсон өвчтөнг идэвхтэй хяналтанд авсан тоо, хувиар Донтох эмгэгийн батжуулах эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хувиар Өөртөө туслах бүлгийн цуглаанд хамрагдсан хүний тоо, хувиар Албадан эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хувиар Нийгмийн нөхөн сэргээх тусламжинд хамрагдсан хүний тоо, хувиар Опиодын орлуулах эмчилгээ хийлгэсэн хүний тоо, хувиар



<p>Өрхийн эмч нар сэтгэцийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн тайлан ЭМТ-305.4</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сэтгэцийн эмгэгээр өрхийн эмчид үзүүлсэн 2. хүний тоо, хувиар Нарийн мэргэжлийн эмчид явуулсан хүний тоо, хувиар 3. Нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан хүний тоо, хувиар 4. Сэтгэцийн эмгэгээр шинээр оношлогдсон хүний тоо, хувиар 5. Сэтгэцийн эмгэгийн улмаас хяналтанд байгаа хүний тоо, хувиар 6. Сэтгэц нөлөөт эм өгсөн хүний тоо, хувиар 7. Зөвлөгөө өгсөн хүний тоо, хувиар
<p>Албадан эмчлүүлсэн, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй хүмүүсийн тайлан ЭМТ-305.7</p>	<ol style="list-style-type: none"> 1. Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй хүмүүсийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдлын тоо, хувиар 2. Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй хүмүүсийн албадан эмчлүүлсэн тохиолдлын тоо, хувиар

Хүснэгт 6. Амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын бүртгэлийн тайлан ба үзүүлэлт

Тайлангийн төрөл	Тооцох үзүүлэлт
<p>Амиа хорлосон тохиолдлын тайлан ЭМТ-305.5</p>	<ol style="list-style-type: none"> 1. Амиа хорлосон тохиолдлын түвшин 100000 хүн амд 2. Амиа хорлосон тохиолдлын стандартчилсан түвшин 100000 хүн амд 3. Амиа хорлосон тохиолдол нас, хүйс, боловсролын түвшин, амиа хорлосон арга, хэлбэр, тоо, хувиар 4. Амиа хорлосон тохиолдлын амиа хорлоход хүргэсэн нөхцөл байдлын тайлан 5. Амиа хорлосон тохиолдлын гадны шалтгааны тайлан
<p>Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын тайлан ЭМТ-305.5</p>	<ol style="list-style-type: none"> 1. Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын хувь 2. Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын нас, хүйс, боловсролын түвшин, амиа хорлох оролдлого хийсэн арга, хэлбэр, тоо, хувиар
<p>Амиа хорлох тохиолдлын урьдчилан сэргийлэлт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохион байгуулсан сургалтын тоо 2. Сургалтад хамрагдсан хүний тоо 3. Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо 4. Тараасан гарын авлага, сурталчилгааны тоо

Зургаа. Мэдээний чанарын хяналт

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл тандалтын мэдээллийн нэгдсэн сан” нь бүртгэл



тандалтын мэдээний чанарыг дараах нийтлэг ба өвөрмөц үзүүлэлтээр тооцож үнэлсэн үнэлгээг жил бүр хийж илгээнэ.

Хүснэгт 7. Чанарын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тодорхойлолт , тооцох аргачлал
Мэдээний үнэн зөв байдал	Батлагдсан маягтын дагуу мэдээг үнэн зөв мэдээлэх байдал
Мэдээний бүрэн байдал	Сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлууд болон амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн нийт тохиолдлыг бүрэн хамарч бүртгэсэн байдал, мэдээлэл бүрэн эсэх (маягт бүрэн бөглөгдсөн эсэх)
Харьцуулахуйц, хэмжигдэхүйц байдал	Мэдээлэл нь тоон үзүүлэлтээр гаргаж болохуйц, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ангилал, бүртгэлтэй дүйцүүлэн харьцуулж болохуйц байх
Бодитой байдал	Тайлант хугацаанд мэдээлсэн тоон үзүүлэлт болон мэдээний нэгтгэлийг бүртгэлийн маягттай дахин тулгах, нягтлан шалгаж, мэдээлэл зөрүүтэй бол мэдээллийн алдаа, шалтгааныг тогтоох
Мэдээ цаг хугацаандаа байх	Тогтоосон хугацаанд мэдээлж байгаа эсэх
Нас баралтын гэрчилгээгээр бүртгэгдсэн тохиолдлын хувь	Нас баралтын гэрчилгээн дээр амиа хорлосон нь тэмдэглэгдсэн байдал
Амиа хорлосон тохиолдлын түвшин	Нийт нас баралтын дотор амиа хорлосон тохиолдлын түвшинг харьцуулж гаргасан үзүүлэлт
Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшин	Гадаад шалтгаант осол гэмтлийн дотор амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшин
Шүүх эмнэлгийн шинжилгээгээр амиа хорлосон болох нь тогтоогдсон хувь	Шүүх эмнэлгийн задлан шинжилгээгээр амиа хорлож нас барсан эсэх нь тогтоогдсон тохиолдол (гадны шалтгаантай эсэхийг ялган тогтоосон хувь)
Прокурорын эцсийн дүгнэлтээр амиа хорлосон нь тогтоогдсон хувь	Хавтаст хэргийн материалтай танилцаж эцсийн дүгнэлтээр амиа хорлосон болох нь тогтоогдсон үзүүлэлт (хэрэг шийдвэрлэсэн байдал)
Мэдээлэл бүрэн бүртгэгдээгүй, тодорхой бус үзүүлэлтийн эзлэх хувь	Нийт мэдээллийн дотор тодорхойгүй мэдээллийн эзлэх хувь



ХАВСРАЛТ 4

Сэтгэцийн эмгэг, тулгамдсан асуудлын бүртгэл мэдээллийн тогтолцоонд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолт, тайлбар

- 1. Сэтгэцийн эмгэг – Олон улсын ангиллын “Сэтгэц, зан үйлийн эмгэгүүд” бүлэгт заасан оношилгооны хэмжүүрээр оношилж болох бүх өвчнийг** 2. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал – нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг 3. Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ – сэтгэцийн эмгэгийн улмаас хүний амьдрах ухаан, харилцаа, хөдөлмөрийн болон оюуны алдагдсан чадварыг нөхөн сэргээх, сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ 4. Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл – сэтгэцийн эмгэгийн улмаас хүн өөрийгөө хянах чадваргүй болж, өөрийн буюу бусдын амь нас, нийгэмд хор хохирол учруулахыг
- 5. Амиа хорлох тохиолдол - Олон улсын эмнэлгийн нэр томъёогоор зориуд санаатайгаар амиа бүрмөсөн хөнөөх үйлдэл болон амиа хорлох оролдлого хийх үйлдлийг нэгтгэсэн ойлголт**
- 6. Амиа хорлож нас барсан тохиолдол – тухайн хүн амын дунд хуанлийн нэг жилийн хугацаанд амиа хорлосны улмаас нас барсан тохиолдлын бодит тоо**
- 7. Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол - тухайн хүн амын дунд хуанлийн нэг жилийн хугацаанд амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын бодит тоо**
- 8. Амиа хорлох үйл явц - амиа хорлох бодол биелэлээ олж, амиа хорлохыг завдсан үйлдэл болон санаатайгаар өөрийн амийг бүрмөсөн хөнөөх үйлдэл үйлдэгдэхийг хамруулсан үйл явц.**
- 9. Өвчний олон улсын ангилал “Зориуд санаатайгаар өөрийгөө хорлох Х60 - Х84” – Эрүүл мэндийн практикт тохиолдох бүхий л өвчлөлийг тодорхой шалгуурын дагуу ангилан бүлэглэсэн тогтолцоо бөгөөд бичгээр илэрхийлсэн амиа хорлох үзэгдлийн оношийг үсэг тоогоор илэрхийлэх кодонд шилжүүлснээр мэдээг хадгалах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх ажлыг хялбаршуулсан хэлбэр юм. Энэхүү ангилал нь Өвчний олон улсын 10 дугаар ангиллаас салбарласан ангилал бөгөөд бүртгэл мэдээлэл тусламжийн тогтолцоонд хэрэглэгдэнэ.**
- 10. Мэдээний эх сурвалж – амиа хорлох тохиолдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд мэдээ өгч байгаа бүхий л байгууллагууд**
- 11. Мэдээний сан – холбогдох маягт, үнэлгээний хуудас, мэдээний хуудсаар цугларсан мэдээг нэгтгэн үүсгэсэн сан**
- 12. Амиа хорлох тохиолдлын бүртгэл мэдээллийг хариуцсан мэргэжилтэн – аймаг, дүүрэгт ажиллаж байгаа амиа хорлох тохиолдлын бүртгэл мэдээллийн тогтолцооны анхдагч нэгжийн амиа хорлох тохиолдолтой холбоотой бүхий л мэдээ мэдээллийг хариуцах ажилтан**
- 13. Амиа хорлох тохиолдлын тархалт – өмнөх онд бүртгэгдсэн амиа хорлох оролдлого хийсэн хүний тоо ба тухайн жилд шинээр бүртгэгдсэн амиа хорлох үзэгдлийн нийт тохиолдлын нийлбэр**
- 14. Амиа хорлолтын түвшин - тухайн жилийн 100000 хүн амд ноогдох амиа хорлох үзэгдлийн шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо бөгөөд нийт тохиолдлын тоог 100000 хүн амд үржүүлж нийт хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт**
- 15. Архи, согтууруулах ундаа- Хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2 хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, пиво, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи согтууруулах ундаанд хамаарна.**



- 16. Мансууруулах эм, бодис** – донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенци, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ.
- 17. Хамаарал ба донтолт** - Тухайн бодисыг олон давтан хэмжээг ихэсгэх байгалаар хэрэглэх ба хэрэглээг бууруулахад (багасгахад) уур бухимдал зэрэг таагүй мэдрэмж төрж тухайн бодисын нэхэх мэдрэмжүүд үүсч улмаар бие сэтгэцийн доройтолд хүргэнэ.



Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд

2024.04.04

СЭМҮТ-өөс амиа хорлолтой холбоотой өгөх санал

1. Амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтох эмгэгтэй хүний тулгамдсан асуудлуудын тохиолдол гэсэн 4 нь төрлөөр мэдээллийг Эрүүл мэндийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам гэсэн 4 яамны хамтарсан “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийг бүртгэх **“тандалтын тогтолцоо”** нэгсэн санг байгуулж мэдээллийн тус сангаас сар тутам нэгдсэн мэдээлэлийг гаргадаг байх.
2. “Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийн” мэдээллийг хамгийн багадаа дараах 24 нэр бүхий байгууллагуудаас харьяа яамнууд нь цуглуулж нэгтгэж бүртгэх нэгдсэн **тандалтын тогтолцоонд** мэдээлдэг байх. Үүнд:
 - Эрүүл мэндийн яам
 - Хууль зүй дотоод хэргийн яам
 - Монгол Улсын ерөнхий прокурорын газар
 - Боловсрол шинжлэх ухааны яам
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
 - ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
 - Нэгдсэн үндэсний байгууллага
 - Монгол Улсын ерөнхий прокурорын газар,
 - Монгол улсын үндэсний статистикийн хороо
 - Эрүүл мэндийн хөгжлийн төв
 - Цагдаагийн ерөнхий газрын, Хар тамхитай тэмцэх хэлтэс
 - Цагдаагийн ерөнхий газрын, Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах хэлтэс
 - Цагдаагийн ерөнхий газрын, Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс
 - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
 - Гэмтэл согог судлалын үндэсний төв
 - Шүүх шинжилгээний ерөнхий газар
 - Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв
 - Нийслэлийн эрүүл мэндийн газар
 - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)
 - Нийслэлийн түргэн тусламж 103
 - Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
 - Аддиктологийн төв
 - Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
 - Хүүхдийн тусламж 108 утас гэсэн нэр бүхий байгууллагуудаас мэдээллийн албан ёсоор авдаг байх



3. Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийх, амиа хорлож нас барах, архи мансууруулах бодисын хэрэглэхээс урьдчилан сэргийлэх тохиолдлын тоог бууруулахыг тулд тухайн аймаг, дүүрэг, сум, багийн нутаг дэвсгэрт нь тухайн орон нутгийн засаг даргын удирдлага дор “Сэтгэц нийгмийн сэргээн засах төв”-үүдийг эмч, сэргээн засахын мэргэжилтэн, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, донтогчийн мэргэжилтэн, бүртгэл мэдээллийн мэргэжилтэн гэх мэт мэргэжлийн хүмүүсээр бүрдүүлж байгуулах шаардлагатай байна.
4. Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуульд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тус хөтөлбөр нь багш, эцэг эх, хүүхэд, залуус, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан тус бүрд нь чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг ялгаатай олгох
5. ЕБС-ийн болон Их дээд сургууль дээр сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг төвүүдийг чанартай тогтмол ажиллуулах
6. ЕБС-д орж буй сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой хичээлүүдийг орж буй багшийг сургах, чадваржуулах шаардлагатай байна.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрдмийн зөвлөлийн 2023 оны 09 сарын 19 өдрийн №02-оор хурлаар батлав.

СЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн дарга:*В.Б*.....В.Баярмаа

**“МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО, АМИА ХОРЛОЖ
НАС БАРСАН ТОХИОЛДОЛ, АРХИ МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХЭРЭГЛЭГЧ
БОЛОН ДОНТОГЧИЙГ БҮРТГЭХ МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЖ ХОЛБОГДОХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГДСЭН СҮЛЖЭЭГ ҮҮСГЭХ”
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ТӨСӨЛ**

Төслийн удирдагч: В. Баярмаа АУ-ны доктор

Судалгааны ажлын зохицуулагч: Т. Ганцэцэг АУ-ны доктор , дэд профессор

Төслийн зөвлөх: Э. Оюунсүрэн, АУ-ны доктор , дэд профессор

Төслийг багийн судлаачид :

АУ-ны магистр Л. Эрдэнэсүвд
АУ-ны -ны магистр Э. Маралмаа
Ахлах мэргэжилтэн Х.Цогтбаяр

Улаанбаатар хот
2023 он



Үндэслэл: Амиа хорлолт нь нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болсоор байгаа бөгөөд (ДЭМБ, 2021) өсвөр насныхны нас баралтын тэргүүлэх шалтгааны 4 дүгээрт амиа хорлолт орж, амиа хорлолтын нийт тохиолдлын 77% нь хөгжиж буй болон ядуу буурай орнуудад бүртгэгдэж байна. Монгол улсын хувьд 2021 оны байдлаар, 100000 хүн амд ноогдох амиа хорлож нас барсан дундаж тохиолдлын тоо 15.0 байгаа нь дэлхийн дунджаас (10.6), 4.4-өөр, бүсийн дунджаас (10.2) 4.8-аар илүү байгаа нь Номхон далайн Баруун эргийн бүсийн хэмжээнд 5 дугаарт орж буй үзүүлэлт болж байна. Манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 16.9 мянган хүн нас барснаас 2.8% орчим нь амиа хорлож нас баржээ. 2010-2019 оны дунджаар нийт нас барсан хүн амын 60.5%, амиа хорлож нас барсан тохиолдлын 85% нь эрэгтэй хүйсийнх байв. Монгол улсын Эрүүл мэндийн үзүүлэлт 2021- оос үзвэл 2021 онд 483 хүн амиа хорлож нас барсан ба энэхүү үзүүлэлтийг 10 000 хүн амд харьцуулахад 1.5 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 19, 2020 онтой харьцуулахад 32 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Дэлхий дахинаа амиа тохиолдлуудын ихэнх хувийг боомилох, галт зэвсгээр өөрийгөө хөнөөх аргууд эзэлдэг ба хөдөө аж ахуй, газар тариалан хөгжиж буй бага болон дунд орлоготой улс орнуудад пестицидээр өөрийгөө хордуулах аргыг илүү хэрэглэж байна. Харин Монгол улсад өөрийгөө боомилох (n=434), галт зэвсгээр өөрийгөө хөнөөх (n=15), санаатайгаар өндрөөс үсрэх (n=8) аргууд нь нас баралтын тэргүүлэх 3 шалтгаан болж байна. Монгол улсад амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшнийг тодорхойлох судалгаа нь хязгаарлагдмал түвшинд 1997, 2008 онуудад хийгдсэн ба 2017 онд Монгол улсын Ерөнхий прокурорын газраас хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгааг тус тус хийжээ. Гэвч өнөөгийн байдлаар хүн амын дундах амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлын түвшнийг үндэсний хэмжээнд өргөн цар хүрээтэй хийсэн судалгаа байхгүй, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо байхгүй байгаа нь салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад саад болсоор байна. Нөгөө талаас НҮБ болон ДЭМБ-ын 2017 оны мэдээгээр дэлхий дээр 15-64 насны ойролцоогоор 271 сая хүн хууль бусаар мансууруулах бодис амьдралдаа нэг удаа хэрэглэсэн, мөн 2.3 тэрбум хүн архи, согтууруулах ундааг хэрэглэдэг гэсэн тооцоо байдаг. Өнөөдөр дэлхийд 35 сая хүн мансуурах бодис хэрэглэх эмгэг, 289 сая хүн архинд донтох эмгэгээр шаналж байна гэсэн тооцоо бий.

Донтох эмгэг гэдэг нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний улмаас эмнэлзүйн болон үйл ажиллагааны алдагдал илэрч, энэ нь хөдөлмөрийн чадвар алдалт, ажил сургууль завсардалтад хүргэдэг эмгэгийг хэлнэ. Мансууруулах бодис хэрэглэх эмгэгийг эмчлэхгүй бол нийгэм эдийн засагт олон сөрөг үр дагаврыг бий болгодог болохыг судлаачид тогтоогоод байна. Тухайлбал хувь хүний бүтээлч байдал алдагдсанаар ажил сургуулиа хаяж өрхийн орлого буурах, эрүүл мэндэд зарцуулах өртөг зардал нэмэгдэх, үүнийг дагаад хууль эрх зүй, нийгмийн халамж, бусад нийгмийн салбарт зарцуулах нийт зардал давхар нэмэгддэг байна. Тиймээс хүн амын дунд нотолгоонд суурилсан мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүнд цогц тусламж үзүүлэх нэн шаардлагатай байна². Өнөөдөр дэлхий дээр маш олон



төрлийн үр дүнтэй эмчилгээний аргууд байгаа боловч, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн цөөхөн хувь нь эмчилгээнд хамрагдаж, тусламж үйлчилгээ авч байна. Жишээлбэл, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй 7 хүн тутмын нэг нь эмчилгээ, тусламж үйлчилгээнд хамрагдаж байна гэсэн тооцоо байна³. Түүнчлэн ДЭМБ-ын тайланд нийт 103 улс оронд хийсэн судалгаанаас харахад 11.9% нь архинд донтох эмгэгтэй байна⁴. Үүнээс харахад архи, мансууруулах хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн эзлэх хувь жилээс жилд ихсэж байгаа боловч эмчилгээ үйлчилгээнд хамрагдах байдал нь хангалтгүй байсаар байна гэжээ.

Манай улсад мансууруулах бодисын хэрэглэгчийг тогтоосон судалгаанууд нэлээдгүй хийгджээ^{5, 6, 7, 8}. Тухайлбал ДЭМБ-ын санхүүжилтээр НЭМГ, Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг (ТМБИХ) хамтарч ASSISST хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаагаар дэгдэмхий уусгагч бодисын хэрэглээ 5.3% байсан ба сэтгэц идэвхт бодисын хэрэглээ 22% (33) байгаагаас каннабис (8.7%), харин тайвшруулах, нойрсуулах эм (8%) зонхилж байна. Мөн ЕБС-ийн 9-10-р ангийн 1000 сурагчдын дунд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 9% нь мансууруулах бодис хэрэглэж байсан⁹. Судалгааны асуултад 2.9% бензин цавуу, 1.8% каннабис, 0.9% экстази хэрэглэж үзсэн гэж хариулжээ¹⁰. Харин сэтгэцэд идэвхт эм бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд 2012 онд улсын хэмжээнд 40 тохиолдол бүртгэгдэж байсан 2021 онд 86 буюу 2 дахин нэмэгдсэн байна. 2021 онд сэтгэц идэвхт эм бодисын хэрэглээний улмаас 40 хүн эмчилгээнд хамрагдсан¹¹. Үүнээс гадна СЭМҮТ-ийн 2013 оны Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаагаар архинд донтох эмгэг 6.2% байсан бөгөөд 1986-1992 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад архинд донтох эмгэг 40 дахин ихэссэн байна¹². Дээрх судалгаануудаас харахад мансууруулах бодист донтох эмгэгийн эмчилгээний талаарх хийгдсэн судалгаа харьцангуй цөөхөн, архи, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүс хаана, ямар тусламж үйлчилгээ авч байгаа нь тодорхойгүй нэгдсэн бүртгэлийн системгүй байна. Үүнээс гадна архи, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүст үйлчилгээ үзүүлдэг төрийн болон ТББ байгууллагууд өөр өөрийн гэсэн тайлан мэдээ байгаа боловч эдгээрийг нэгтгэж, суурь тоог гаргадаг тогтолцоо одоог хүртэл бий болоогүй байна.

Гэтэл Монгол улсын ерөнхийлөгчийн 2019 оны 05 сарын 30 өдрийн 104 дүгээр дугаартай зарлигийн 12 ба 13 дугаарт зүйлд Монгол улсын хэмжээнд амиа хорлож нас барсан болон амиа хорлох оролдлого тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болох гэсэн бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” тунхагласан зорилгын 3.5.1-д “Үндэсний хэмжээнд мансууруулах бодис ба архинд донтох эмгэгийн тархалт, эмчилгээний хамралтыг судлах”, 3.4.2-д “Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин” заасан шалгуурыг хангах ажлын хүрээнд 2018-2019 онд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс гаргасан (06/05 тоот зөвлөмж, 1а/2551



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



албан тоот) үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллах үүргийг биелүүлэхийн тулд энэхүү судалгааны ажлыг хийх хэрэгцээ шаардлага буюу үндэслэл болж байна.

Зорилго: Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэн, журам боловсруулж, эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах

Зорилтууд:

1. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах стандарт асуумж, маягтыг боловсруулах, батлуулах, нэгдсэн мэдээллийн цахим санг үүсгэх, одоогийн бүртгэлийн маягтын чанарт үнэлгээ, дүгнэлт хийх
2. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг хөтлөх, нэгдсэн сүлжээнд оруулах зэрэг бусад үйл ажиллагаануудыг зохицуулах 4 сайдын (эрүүл мэнд боловсрол, шинжлэх ухаан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй дотоод хэргийн) хамтарсан журам боловсруулах
3. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч зэргийг бүртгэх мэдээллийн санг холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн цахим сүлжээг үүсгэх

Санхүүжилт: Эрүүл мэндийг дэмжих сан

Нийт төсөв: **66.185.000** төгрөг

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

Судалгааны загвар: Уг судалгааны ажлыг аналитик болон чанарын судалгааны нэг агшны загвараар, асуумж болон баримтын судалгааны аргыг ашиглаж 3 үе шаттай хийнэ.

Судалгааны хамрах хүрээ: Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах стандарт асуумж, маягтыг



боловсруулах, батлуулах, нэгдсэн мэдээллийн цахим санг үүсгэхийн тулд судалгааны асуумжийг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын харьяа болон олон улсын зэрэг бусад нийт 22 байгууллагатай хамтарч судалгаа хийх, журам боловсруулах болон сургалт хийж ажиллана.

Хамтран ажиллах байгууллагуудын нэрс

№	Байгууллагын нэрс
1.	Эрүүл мэндийн яам
2.	Хууль зүй дотоод хэргийн яам
3.	Боловсрол шинжлэх ухааны яам
4.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
5.	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
6.	Нэгдсэн үндэсний байгууллага
7.	Монгол Улсын ерөнхий прокурорын газар,
8.	Монгол улсын үндэсний статистикийн хороо
9.	Эрүүл мэндийн хөгжлийн төв
10.	Цагдаагийн ерөнхий газрын -Хар тамхитай тэмцэх хэлтэс
11.	Цагдаагийн ерөнхий газрын - Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах хэлтэс
12.	Цагдаагийн ерөнхий газрын - Мэдээлэл холбоо, дүн шинжилгээний хэлтэс
13.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
14.	Гэмтэл согог судлалын үндэсний төв
15.	Шүүх шинжилгээний ерөнхий газар
16.	Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв
17.	Нийслэлийн эрүүл мэндийн газар
18.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (хор судлал, статистик бүртгэл)
19.	Нийслэлийн түргэн тусламж 103
20.	Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
21.	Аддиктологийн төв
22.	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
23.	Хүүхдийн тусламж 108 утас

Арга аргачлал ба хэрэглэгдэхүүн:

I шатанд Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн систем, бүртгэлийн маягт зэргийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний



статистикийн хороо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах ёс зүйн зөвшөөрлийг авч бүлгийн ярилцлага болон баримтын судалгааны арга ашиглаж 2022 оны 10 дүгээр сараас эхэлж 11 сард судалгаа хийнэ.

II шатанд. Нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд үндэслэж Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн нэг системийг хэрхэн бүртгэх, хөтлөх, нэгдсэн сүлжээнд оруулахад дээрх байгууллагууд ямар үүрэгтэй оролцох, нууцлалыг хэрхэн хангах, мэдээллийг нэгтгэж давхардлыг арилгах зэрэг бусад үйл ажиллагаануудыг зохицуулах журам боловсруулж, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах эсвэл засгийн за газрын тогтоол гаргуулахыг 2023 оны 11 дүгээр сараас 2023 оны 12 сарын хооронд хийнэ.

III. шатанд. Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогч зэргийг бүртгэх мэдээллийн санг холбогдох байгууллагуудын дундын нэгдсэн нэг сүлжээг үүсгэх ажлыг 2023 оны 12 сараас эхлэн 3 сарын хугацаанд явуулна. Судалгааны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааны асуумжийг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монгол улсын үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын харьяа нийт 23 Амиа хорлолт, амиа хорлох оролдлого ба мансууруулах бодис хэрэглэгчдийн мэдээллийн нэгдсэн систем үүсгэх ажлын хэсгийн гишүүдийн нэрс байгууллагаас авна.

Судалгааны асуумж нийт 4 бүлэг, 231 асуултаас бүрдэнэ.

1. Амиа хорлож нас барсан тохиолдлыг бүртгэх маягыг үнэлэх асуумж – 47 асуулттай
2. Амиа хорлох оролдлогын тохиолдлыг бүртгэх маягыг үнэлэх асуумж – 58 асуулттай
3. Согтууруулах ундаа хэрэглэгчдийн мэдээллийг бүртгэх маягыг үнэлэх асуумж – 58 асуулттай
4. Мансууруулах бодис хэрэглэгчдийн мэдээллийг бүртгэх маягыг үнэлэх асуумж – 68 асуулт

Асуумж боловсруулахад шаардлага ба ашигласан эх сурвалж:

Бид Монгол Улсын хэмжээнд амиа хорлож нас барсан, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдол болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх, үндэсний хэмжээнд ашиглах олон улсын стандартад нийцсэн бүртгэлийн



маягтыг салбар бүрийн онцлогт тохируулж боловсруулж салбар дундын нэгдсэн системийг үүсгэх нөхцөлийн бүрдүүлэхийн тулд бид өнөөгийн байдлыг үнэлэх зорилгоор судалгааны асуумжийг боловсруулсан.

Амиа хорлож нас барсан ба оролдлогын тохиолдлыг бүртгэх маягтыг үнэлэх асуумж, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг, мэдээлдэг бүртгэлийн үнэлэх, судлах асуумжийг боловсруулахад:

- Дэлхийн тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн холбогдох метадатанд байгаа бүртгэлийн өгөгдлүүд (<https://unstats.un.org/sdgs/metadata/>),
- ДЭМБ-аас жил бүр бүх улс орноос амиа хорлолт болон сэтгэц идэвхт бодис, архины мэдээллийг хүлээж авдаг мэдээллийн санд байгаа бүртгэлийн өгөгдлүүд (<https://www.who.int/data/global-health-estimates>)
- Олон улсад хэвлэгдсэн судалгааны өгүүлүүд
- Монгол улсын эрүүл мэндийн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 611 дүгээр бүртгэлийн маягтуудаас бүртгэх маягтыг үнэлэх асуумж, осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33, амиа хорлох тохиолдлыг бүртгэх маягт СЭ-4 маягт, мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн бүртгэл СЭ -6 зэрэг олон улсын болон өөрийн орны бүртгэлийн маягтууд байгаа үзүүлэлтүүдийг зэргээс мэдээллийг авч судалгааны асуумжийн 4 картыг боловсруулж судалгаандаа хэрэглэхээр бэлтгэсэн.

Хүснэгт 1. Хамрагдагсдыг судалгаанаас хасах болон оруулах шалгуурууд

Судалгаанд хамруулах шалгуур	Судалгаанаас хасах шалгуур
<ul style="list-style-type: none"> • Судалгаанд оролцох байгууллага нь улсын хэмжээн дэх тохиолдлуудыг бүртгэж оны эцэст нэгдсэн тайлан гаргадаг байгууллага байна. • Тохиолдлын тоогоо бүртгэх өөрийн гэсэн батлагдсан маягттай байх • Тохиолдлоо бүртгэх салбарын түвшинд мэдээлэл оруулдаг нэгдсэн цахим мэдээллийн сантай байх өөрийн батлагдсан маягттай • Байгууллагын удирдлагаа нь таниулсан зөвшөөрөлтэй танилцаж өөрийн алба нэгжийг судалгаанд 	<ul style="list-style-type: none"> • Тохиолдлын тоогоо бүртгэх өөрийн гэсэн батлагдсан маягтгүй байх • Тохиолдлын тоогоо бүртгэх салбарын түвшинд мэдээлэл оруулдаг нэгдсэн цахим мэдээллийн сангүй байх • Судалгаанд оролцохоос татгалзсан

оролцохыг албан ёсоор зөвшөөрсөн
байх.

Арга аргачлал: Баримтын судалгааны аргыг ашиглаж

Судалгааны арга аргачлалыг дараах 3 үе шаттайгаар явуулна. Нэгдүгээрт, одоо байгаа эрүүл мэнд болон бусад байгууллагуудын амиа хорлолт, амиа хорлох оролдлого болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэж буй бүртгэлд үнэлгээ хийн бүртгэлийн маягт боловсруулах. Хоёрдугаарт үнэлгээнээс боловсруулсан мэдээллийн өгөгдлийн хоёр үе шаттай Дэльфи аргаар үнэлэх. Гуравдугаарт, Дэльфи аргаар боловсруулсан асуумжын баталгаат чанарыг үнэлнэ.

1. Эрүүл мэндийн байгууллага болон бусад байгууллагуудын амиа хорлолт, амиа хорлох оролдлого болон архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэдэг бүртгэлийн системд үнэлгээ хийн, бүртгэл мэдээллийн асуумж боловсруулах. Амиа хорлолт, амиа хорлох оролдлого болон архи мансууруулах бодисын донтолтод нөлөөлсөн эрсдэлт хүчин зүйлс, нөхцөл байдал, гэр бүл, нийгмийн харилцаа болон хүн амын ямар бүлэг болох талаар мэдээлэл оруулсан байх.

Асуумжын загвар

1. Нэгдүгээр шатнаас боловсруулсан асуумжыг хоёр үе шаттайгаар судалгааны зөвлөх багын гишүүдээс авах.
2. Судалгааны зөвлөх багын гишүүдээс 5 онооны Лайкерт аргаар асуулт тус бүрийн ач холбогдолыг үнэлүүлэх
